



Schweizerische Eidgenossenschaft
Confédération suisse
Confederazione Svizzera
Confederaziun svizra

Swiss Agency for Development
and Cooperation SDC

МОНГОЛ УЛС ДАХЬ БИЧИЛ УУРХАЙ БА ХҮНИЙ ЭРХ 2012

СУДАЛГААНЫ ТАЙЛАН

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

Улаанбаатар хот
2012 он

АГУУЛГА

ӨМНӨХ ҮГ

Товчилсон үгсийн жагсаалт
Хүснэгтийн жагсаалт
Зургийн жагсаалт

1. УДИРТГАЛ

2. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

- 2.1 Судалгааны зорилго
- 2.2 Судалгааны загвар
- 2.3 Судалгааны хамрах хүрээ
- 2.4 Мэдээлэл цуглуулалт, боловсруулалт
- 2.5 Судалгаанд хамрагдсан бичил уурхайгаар ашигт малтмал олборлогч иргэдийн нийгэм хүн ам зүйн шинж байдал

3. БИЧИЛ УУРХАЙГААР ХУВИАРАА АШИГТ МАЛТМАЛ ОЛБОРЛОГЧ ИРГЭДИЙН ХҮНИЙ ЭРХ,ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН БАЙДАЛ

- 3.1 Бичил уурхай эрхлэгч иргэдийн түр буюу байнга оршин суух газраа сонгох эрхийн хэрэгжилт
 - 3.1.1 Иргэний бүртгэлд хамрагдалт
- 3.2 Бичил уурхай эрхлэгч иргэдийн хүрэлцээтэй түвшинд аж төрөх, өмчлөх эрхийн хэрэгжилт
 - 3.2.1 Хувиараа ашигт малтмал олборлох үйл ажиллагаа, аюулгүй байдал
 - 3.2.2 Амьжиргааны түвшний хүрэлцээтэй байдал
 - 3.2.3 Бичил уурхай эрхлэгч иргэдийн газар зэмших, өмчлөх эрхийн хэрэгжилт
- 3.3 Бичил уурхай эрхлэгч иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхийн хэрэгжилт
- 3.4 Бичил уурхайн эрхлэгч иргэдийн оролцооны эрхийн хэрэгжилт

4. УУЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БАЙГАЛЬ ОРЧИН БА БЭЛЧЭЭРИЙН МАЛ АЖ АХУЙД ҮЗҮҮЛЖ БУЙ НӨЛӨӨЛӨЛ

- 4.1 Уул уурхайн үйл ажиллагааны байгаль орчин ба бэлчээрийн мал аж ахуйд үзүүлж буй нөлөө
- 4.2 Уул уурхайн үйл ажиллагааны нөлөөлөлд өртсөн орон нутгийн иргэдийн газар эзэмших, ашиглах, өмчлөх эрхийн хэрэгжилт
- 4.3 Нүүлгэн шилжүүлэлт, нөхөн төлбөрийн зохицуулалт
- 4.4 Уул уурхайн компаниудын байгалийн нөхөн сэргээлтийн үйл ажиллагаа

5. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

§ Хавсралт

Судалгааны ажлын удирдамж
Судалгааны хэрэглэгдэхүүн

Судалгааны баг

Ц.Одгэрэл	Судлаач, МУИС-ийн НШУС-ийн Социологи, Нийгмийн ажлын тэнхмийн докторант
А.Энхтөр	Хүний эрхийн Үндэсний Комисс, Гомдол, хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтсийн дарга
Г.Агар-Эрдэнэ	Хүний эрхийн Үндэсний Комисс, Гомдол, хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтсийн референт
Т.Энхцэцэг	Швейцарийн хөгжлийн агентлаг, Тогтвортой бичил уурхай төслийн бичил уурхайн бодлогын эксперт

ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ

Товчилсон үг	Дэлгэрэнгүй
ААНБ	Аж ахуйн нэгж, байгууллага
АМГ	Ашигт малтмалын газар
АМХЭГ	Ашигт малтмалын хэрэг эрхлэх газар
БОАЖЯ	Байгаль орчин аялал жуулчлалын яам
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ДОХ	Дархлалын олдмол хомсдлын хам шинж
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ИНХ	Иргэдийн нийтийн хурал
МАА	Мал аж ахуй
НД	Нийгмийн даатгал
ХЭҮК	Хүний эрхийн Үндэсний Комисс
ХАМО	Хувиараа ашигт малтмал олборлогч
ТБУТ	Тогтвортой бичил уурхай төсөл
ШХА	Швейцарийн хөгжлийн агентлаг
ЭМД	Эрүүл мэндийн даатгал

Хүснэгтийн жагсаалт:

- Хүснэгт 2.1 Судалгааны арга зүйн бүтэц
- Хүснэгт 2.2 Судалгааны хамрах хүрээ
- Хүснэгт 2.3 Бичил уурхай эрхлэгч иргэдийн нийгэм, хүн ам зүйн шинж байдал
- Хүснэгт 3.1 Судалгаанд хамрагдсан бичил уурхай эрхлэгчдийн иргэний бүртгэлийн талаарх мэдээлэл
- Хүснэгт 3.2 Бусад аймаг, сумдаас ирсэн бичил уурхай эрхлэгчдийн иргэний бүртгэлд хамрагдаагүйн шалтгаан
- Хүснэгт 3.3 Давхар ажил эрхэлдэг бичил уурхай эрхлэгчдийн тоо
- Хүснэгт 3.4 Бичил уурхай эрхлэгчдийн газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн хэрэгжилт
- Хүснэгт 3.5 Бичил уурхайн үйл ажиллагааны улмаас амь нас, эрүүл мэндээрээ хохирсон хүний тоо, үүнээс эмнэлгийн тусламж шуурхай авсан хүний тоо
- Хүснэгт 3.6 ХАМО иргэдийн уул уурхайн асуудлаарх оролцооны эрхийн хэрэгжилт

Зургийн жагсаалт:

- Зураг 3.1 Шилжин ирсэн болон түр хугацаагаар бичил уурхай эрхэлж байгаа иргэдийн иргэний бүртгэлд хамрагдсан байдал
- Зураг 3.2 Бичил уурхай эрхэлснээр бичил уурхай эрхлэгчдийн амьжиргааны түвшинд гарсан өөрчлөлтийн үнэлгээ
- Зураг 3.3 ХАМО иргэдийн эмнэлгийн тусламж үйлчилгээг шуурхай авч чадаагүйн шалтгаан
- Зураг 3.4 Бичил уурхайн үйл ажиллагаа эрхэлж байгаа ХАМО иргэдэд тулгарч буй бэрхшээл

Матрицын жагсаалт

- Матриц 3.1 Судалгаанд хамрагдсан бичил уурхай эрхлэгчдийн хөдөлмөр эрхлэлтийн нөхцөл байдал
- Матриц 3.2 Бичил уурхай эрхлэгчдийн газар эзэмших, ашиглах, өмчлөх эрхийн хэрэгжилт
- Матриц 3.3 ХАМО иргэдийн эрхэлж буй ажлаас шалтгаалсан өвчлөл болон ХАМО иргэдэд эмч нарын хандах хандлага
- Матриц 4.1 Бэлчээрийн мал аж ахуйд уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагааны үзүүлж буй сөрөг нөлөөлөл
- Матриц 4.2 Лицензийн талбайд орсон малчдын тоо болон нөхөн төлбөр авч буй малчдын тоо

НЭГ. УДИРТГАЛ

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс бүрэн эрхийнхээ хүрээнд уул уурхайн үйл ажиллагаа нь Үндсэн хуулиар баталгаажуулсан хүний эрх, эрх чөлөөний заалтын хэрэгжилтэд хэрхэн нөлөөлж буйд шалгалт, судалгаа хийж, түүний мөрөөр авах арга хэмжээний талаар санал, зөвлөмж гарган холбогдох байгууллага, албан тушаалтнуудад хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавих зорилгоор “Монгол Улс дахь уул уурхайн салбар ба хүний эрх” судалгааг тодорхой бүс нутгуудад үе шаттайгаар зохион байгуулж байгаа билээ.

Энэхүү судалгааны бүрэлдэхүүн хэсэг болох “Монгол улс дахь бичил уурхай ба хүний эрх” судалгааг Хүний эрхийн Үндэсний Комиссийн судалгааны баг Швейцарийн хөгжлийн агентлагийн Тогтвортой бичил уурхай төсөлтэй хамтран хийж гүйцэтгэлээ. Судалгааны ажлын хүрээнд бичил уурхай дахь хүний эрхийн төлөв байдал, Үндсэн хуульд заасан хүний эрхийн хэрэгжилтийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, хүний эрхийн зөрчлийн шалтгаан, түүнд нөлөөлж буй хүчин зүйлсийг судалсан болно. Судалгааны тайланг Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүдийн хурлаар хэлэлцүүлж гишүүдээс гарсан санал зөвлөмжийг тусган 10 дугаар сарын 10-12-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо зохион байгуулах “Уул уурхай, хүний эрхийн асуудал Монгол Улсад” сэдэвт олон улсын чуулганд илтгэл тавьж, хэлэлцүүлэх юм.

Судалгааны баг бичил уурхай эрхлэгчид олноор төвлөрсөн Өвөрхангай аймгийн Уянга, Төв аймгийн Заамар сумдыг хамруулан бичил уурхайгаар ашигт малтмал олборлогч иргэдийн хүний эрх, эрх чөлөөний хэрэгжилтийг түр буюу байнга оршин суух газраа сонгох эрх, амьдралын хүрэлцээтэй түвшинд аж төрөх, газар ашиглах, эзэмших, өмчлөх эрх, эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрх, оролцооны эрхүүдийн хүрээнд судалж холбогдох талуудад хандсан бодлогын зөвлөмжийг боловсруулав.

ХОЁР. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

2.1 Судалгааны зорилго


Бичил уурхай дахь хүний эрхийн төлөв, бичил уурхай эрхлэгч иргэдийн Үндсэн хуулиар баталгаажсан түр буюу байнга оршин суух газраа сонгох, эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах, оролцооны эрхийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх, бичил уурхайн үйл ажиллагаанаас шалтгаалсан хүний эрхийн зөрчил, түүний шалтгаан, уул уурхайн үйлдвэрлэлийн байгаль орчин, уламжлалт бэлчээрийн мал аж ахуйд үзүүлж буй нөлөөллийг судлахад энэхүү судалгааны зорилго оршино.

Судалгааны зорилгын хүрээнд дараах зорилтыг дэвшүүлэв. Үүнд:

- Бичил уурхайгаар ашигт малтмал олборлогч иргэдийн түр буюу байнга оршин суух газраа сонгох, эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах, оролцох эрхийн хэрэгжилтийн байдалд дүн шинжилгээ хийх,
- Бичил уурхайн үйл ажиллагаанаас шалтгаалсан хүний эрхийн зөрчил түүнд нөлөөлж буй хүчин зүйлсийг судлах,
- Уул уурхайн үйлдвэрлэл нь тухайн орон нутгийн малчдын газар нутагтаа амьдрах, амьдралын хүрэлцээтэй түвшинд аж төрөх, газар эзэмших (өвөлжөө, хаваржаа, намаржаа), эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийн хэрэгжилтэд үзүүлж буй нөлөөллийг судлах,
- Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагааны байгаль орчин болон уламжлалт бэлчээрийн МАА-д үзүүлж буй нөлөөлөл, нүүлгэн шилжүүлэлт, нөхөн төлбөрийн асуудлыг судлах,
- Уул уурхайн үйл ажиллагаанаас шалтгаалсан хүний эрхийн зөрчил, хөндөгдсөн эрхийг сэргээх эдлүүлэх үүргээ орон нутгийн захиргааны байгууллага хэрхэн биелүүлж байгаад дүн шинжилгээ хийх,
- Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журмын хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх,
- Бичил уурхайн цаашдын төлөв хандлагын талаарх оролцогч талуудын (бичил уурхай эрхлэгчид, орон нутгийн иргэд малчид, орон нутгийн захиргааны төлөөлөл) санаа бодлыг судлах,
- Судалгааны үр дүн, дүгнэлтэд тулгуурлан бодлогын зөвлөмж боловсруулах,

2.2 Судалгааны загвар

Хүснэгт 2.1 Судалгааны арга зүйн бүтэц



Судалгаанд тоон судалгааны асуулга, чанарын судалгааны бүлгийн болон ганцаарчилсан ярилцлагын аргуудыг хослуулан хэрэглэв.

Асуулгын аргаар бичил уурхайгаар ашигт малтмал олборлогч иргэдийн Үндсэн хуулиар баталгаажсан эрх, эрх чөлөөний (амьдралын хүрэлцээтэй түвшинд аж төрөх, эрүүл аюулгүй орчинд амьдрах, түр буюу байнга оршин суух газраа сонгох, оролцооны эрх) хэрэгжилтийн байдлыг судлав.

Бүлгийн ярилцлагын аргаар бичил уурхайгаар ашигт малтмал олборлож байгаа иргэдийн төлөөллийг хамруулан бичил уурхай эрхлэх явцад хүний эрхийг зөрчсөн үйлдлүүд, түүнд нөлөөлсөн хүчин зүйл, бичил уурхайчид нэр төртэйгээр амьдрах, эрүүл аюулгүй орчинд амьдрах, хөдөлмөрлөх, газар эзэмших, эрүүл мэндээ хамгаалуулах, хөдөлмөрлөх, хүрэлцэхүйц амьжиргааны түвшинтэй байх болон амьдрах орчноо чөлөөтэй сонгох эрхээ эдлэхэд тохиолдож байгаа бэрхшээл, үүнтэй холбоотой хүний эрхийн зөрчлүүдийг гүнзгийрүүлэн шинжиллээ.

Бүлгийн ярилцлагын аргаар орон нутгийн засаг захиргааны байгууллагын төлөөлөл, тодруулбал орон нутгийн удирдлага, асуудал хариуцсан мэргэжилтнүүдийг оролцуулан бичил уурхайн үйл ажиллагаа, бичил уурхай эрхлэгчдийн хүний эрхийг хангах, хамгаалахад орон нутгийн захиргааны байгууллагууд хуулиар хүлээсэн үүрэг хариуцлагаа хэрхэн хэрэгжүүлж байгаа талаар, бичил уурхайгаар ашигт малтмал олборлох үйл ажиллагааны журмын хэрэгжилт болон бичил уурхайн салбарт тулгамдаж байгаа асуудлын талаарх мэдээллийг цуглуулав.

Ганцаарчилсан ярилцлагын аргаар орон нутгийн малчдыг хамруулан уул уурхайн үйлдвэрлэлийн байгаль орчин, бэлчээрийн МАА--д үзүүлж байгаа нөлөөлөл, нүүлгэн шилжүүлэлт, нөхөн төлбөрийн асуудлаар дэлгэрэнгүй мэдээлэл авч дүн шинжилгээ хийлээ.

2.3 Судалгааны хамрах хүрээ

Судалгаанд Өвөрхангай аймгийн Уянга сумын Өлт баг дахь Өлтийн алтны уурхай, Төв аймгийн Заамар сумын Хайлааст баг дахь Заамарын алтны уурхайд бичил уурхайгаар ашигт малтмал олборлогч иргэд, орон нутгийн малчид, орон нутгийн захиргааны байгууллага болон уул уурхайн компаниудын төлөөлөл нийт 306 хүн амыг хамруулав.

Хүснэгт 2.2 Судалгааны талбар ба түүврийн хэмжээ

Аргууд	Зорилтот бүлэг		Бүгд
	Өвөрхангай аймгийн Уянга сум	Төв аймгийн Заамар сум	
Нэг. Бичил уурхай эрхлэгч иргэд			
Асуулга	111	115	226
Бүлгийн ярилцлага	15	20	35
Хоёр. Орон нутгийн иргэд, малчид			
Ганцаарчилсан ярилцлага	10	14	24
Гурав. Орон нутгийн захиргааны төлөөлөл			
Бүлгийн ярилцлага	12	5	17
Дөрөв. Уул уурхайн үйл ажиллагаа явуулж буй компани, ААНБ-ын төлөөлөл			
Ганцаарчилсан ярилцлага	3	1	4
Бүгд	151	155	306

2.4 Мэдээлэл цуглуулалт, боловсруулалт

Судалгааны баг 4 хүний бүрэлдэхүүнтэйгээр Уянга, Заамар сумдад 10 хоног ажиллаж судалгааны мэдээлэл цуглуулав.

Нийт хүчинтэй 226 асуулгын хуудсыг нийгмийн судалгааны SPSS 17 программд мэдээллийн бааз үүсгэн, шивж оруулав. SPSS 17 багц программын тусламжтайгаар мэдээллийн шивэлтийг шалгах, үр дүнгийн хүснэгт боловсруулах, энгийн тархалтын болон хамаарлын шинжилгээг хийв.

Чанарын судалгааны мэдээллийг бүртгэж индексжүүлэх, категорчлох, хэв маягчлах арга техникийг хэрэглэн боловсруулав.

2.5 Судалгаанд хамрагдсан бичил уурхайгаар ашигт малтмал олборлогч иргэдийн нийгэм хүн ам зүйн шинж байдал

“Монгол Улс дахь бичил уурхай ба хүний эрх” судалгаанд хамрагдсан Өвөрхангай аймгийн Уянга, Төв аймгийн Заамар суманд бичил уурхайгаар ашигт малтмал олборлогч иргэдийн нийгэм хүн ам зүйн үндсэн мэдээллийг дараах хүснэгтэд харууллаа.

Хүснэгт 2.3 Бичил уурхай эрхлэгч иргэдийн нийгэм хүн ам зүйн шинж байдал

Сонгосон үзүүлэлтээр	Тоо	Хувь
Судалгаанд хамрагдсан сум		
Уянга	110	48.7
Заамар	116	51.3
Насны бүлэг		
16-17	4	1.8
18-24	22	9.7
25-29	41	18.1

30-39	72	31.9
40-49	50	22.1
50-59	31	13.7
60-аас дээш	6	2.7
Хүйс		
Эрэгтэй	111	49.1
Эмэгтэй	115	50.9
Боловсрол		
Дээд	18	8.0
Тусгай дунд	25	11.1
Бүрэн дунд	97	42.9
Бүрэн бус дунд	50	22.1
Бага	24	10.6
Боловсролгүй	9	4.0
Бүгд	226	100.0

Судалгаанд хамрагдсан бичил уурхай эрхлэгч иргэд (нинжа) дотор насанд хүрээгүй 4 хүүхэд байна. Бичил уурхайгаар ашигт малтмал олборлож буй иргэдийн 72.9 хувийг 25-49 насныхан эзэлж байна.

Жишээ 2.1

Өвөрхангай аймгийн Уянга сумын Өлтийн уурхайд 16 настай гурван эрэгтэй, 17 настай нэг эмэгтэй нийт насанд хүрээгүй 4 хүүхэд хүүхдийн хүнд хөдөлмөрийн жагсаалтад орсон тэвчишгүй, аюултай хөдөлмөр эрхэлж байна. Эдгээр хүүхдүүд бүгд Уянга сумын харьяат бөгөөд сургууль завсардсан байлаа.

(Асуулга судалгааны үр дүн, Өвөрхангай аймгийн Уянга сум)

Боловсролын хувьд бичил уурхайгаар ашигт малтмал олборлож байгаа иргэдийн 80.9 хувь нь бүрэн дунд болон түүнээс доогуур боловсролтой байна. Бичил уурхай эрхлэгчдийн дотор дээд болон тусгай дунд боловсролтой 43 хүн ажиллаж байлаа. Бичил уурхайгаар ашигт малтмал олборлож байгаа иргэдийн нийгэм хүн ам зүйн байдлаас харахад эдийн засгийн идэвхтэй насны, суурь боловсрол эзэмшсэн иргэд зонхилж байна. Уянга сумаас судалгаанд хамрагдсан хүн амын дотор бичил уурхайгаар ашигт малтмал олборлодог төрийн болон хувийн хэвшлийн байгууллагад ажилладаг, иргэд, малчид цөөнгүй байв. Хүйсийн хувьд онцын ялгаа ажиглагдаагүй бөгөөд гэр бүлээрээ буюу нөхөр, эхнэр болон нөхөр, эхнэр хүүхэдтэйгээ хамт ажиллаж байгаа нь түгээмэл ажиглагдлаа.

ГУРАВ. БИЧИЛ УУРХАЙГААР АШИГТ МАЛТМАЛ ОЛБОРЛОГЧ ИРГЭДИЙН ХҮНИЙ ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН БАЙДАЛ

Судалгааны тайлангийн энэ хэсэгт бичил уурхайгаар ашигт малтмал олборлогч иргэдийн Үндсэн хуулиар баталгаажсан түр буюу байнга оршин суух газраа сонгох, амьдралын хүрэлцээтэй түвшинд аж төрөх, газар ашиглах, эзэмших, эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах, оролцооны эрхүүдийн хэрэгжилтийг судалсан судалгааны дүнг танилцуулж байна.

3.1 Бичил уурхай эрхлэгч иргэдийн түр буюу байнга оршин суух газраа сонгох эрхийн хэрэгжилт

3.3.1 Бичил уурхай эрхлэгчдийн иргэний бүртгэлд хамрагдалт

Бичил уурхайгаар ашигт малтмал олборлож байгаа иргэдийн дийлэнх нь Уянга болон Заамар сумын иргэд байна. Уянга сумын Өлтийн уурхайд тус сумын харъяат иргэдээс гадна Өвөрхангай аймгийн Арвайхээр, Хайрхандулаан, Тарагт, Зүйл, Хархорин, Зүүнбаян-Улаан сум болон Орхон аймаг, Улаанбаатар хотоос ирсэн 33 ХАМО иргэний зөвхөн нэг нь иргэний бүртгэлтэй байлаа. Заамар сумын хувьд Орхон, Төв, Архангай, Булган, Төв зэрэг хангайн болон төвийн бүсийн 5 аймгаас бичил ирсэн ХАМО иргэд байгаа бөгөөд Уянга сумтай харьцуулахад иргэний бүртгэлд хамрагдсан байдал сайн байна. (Зураг 3.1)

Хүснэгт 3.1 Судалгаанд хамрагдсан бичил уурхай эрхлэгчдийн иргэний бүртгэлийн талаарх мэдээлэл

Аймаг, сумдын нэр	Тоо	Хувь
Өлтийн уурхай		
Уянга	76	
Хайрхандулаан	2	.9
Тарагт	3	1.3
Арвайхээр	9	4.0
Зүйл	3	1.3
Хархорин	4	1.8
Зүүн-Улаанбаян	4	1.8
Орхон	1	0.4
Улаанбаатар	7	3.1
Бүгд	109	100.0
Заамарын уурхай (n=117)		
Заамар	97	43.4
Орхон аймаг	6	2.7
Архангай, Хашаат	5	2.2
Булган аймаг	1	0.4
Төв, Баянхангай, Атар	6	2.7
Сэлэнгэ	1	0.4
Хөвсгөл	1	0.4
Бүгд	226	100.0

Уянга суманд бусад сумдаас ирсэн ХАМО иргэдийн 97 хувь нь иргэний бүртгэлгүй, Заамар суманд бусад аймаг, сумдаас ирж хувиараа ашигт малтмал олборлож байгаа иргэдийн 78.1 хувь нь иргэний бүртгэлд хамрагджээ. Уянга суманд хувиараа ашигт малтмал олборлодог бүртгэлгүй иргэд иргэний бүртгэл хийлгэх сонирхолгүй байхад Заамар суманд бичил уурхай эрхэлж буй бүртгэлгүй иргэд иргэний бүртгэлд хамрагдах хүсэлтэй байна. Уянга суманд бүртгэлгүй ХАМО иргэд ашигт малтмал олборлож амьжиргаагаа дээшлүүлсний дараа өөрийн харъяалалтай орон нутаг руу буцах зорилгоор тухайн бичил уурхайн үйл ажиллагаа эрхэлж байгаа орон нутагт иргэний бүртгэлд хамрагдах сонирхолгүй байдаг байна. Эдгээр иргэд бүгд өөрийн орон нутагтаа бүртгэлтэй гэжээ.



Бичил уурхайд ажиллаж байгаа иргэд түр буюу байнга оршин суух газраа сонгох эрхээ эдэлж чадахгүйд хүрч байгаа дараах шалтгаануудыг нэрлэлээ. Үүнд:

- 48.6 хувь нь өөрийн нутаг орондоо бүртгэлтэй тул одоо байгаа газраа бүртгүүлэх шаардлагагүй,
- 27 хувь нь Уянга болон Заамар сумын иргэний бүртгэлийн хэлтэс, албанд огт хандаж байгаагүй,
- 13.5 хувь нь Уянга болон Заамар сумын захиргааны байгууллага нь иргэний бүртгэлд бүртгэхээс татгалздаг, хүсэлтийг нь хүлээж авдаггүй, хүнд сурталтай,
- 5.4 хувь нь шилжүүлгээ хийлгээгүй, бичиг баримт байхгүй,
- 5.4 хувь нь буцаж нүүнэ, бүрмөсөн суурьших эсэхээ шийдээгүй гэж тус тус хариулжээ.

Хүснэгт 3.2 Бусад аймаг, сумдаас ирсэн бичил уурхай эрхлэгчдийн иргэний бүртгэлд хамрагдаагүй шалтгаан

Сонгосон үзүүлэлтээр	Уянга сум	Заамар сум	Бүгд
Өөрийн орон нутагтаа бүртгэлтэй	58.1	-	48.6
Одоогийн оршин сууж буй орон нутгийн иргэний бүртгэлийн албанд хандаагүй	32.3	-	27.0
Уянга, Заамар сумын бүртгэлийн байгууллага нь бүртгэл хийхээс татгалздаг, хүсэлтийг нь хүлээж авдаггүй, хүнд сурталтай	-	83.5	13.5
Шилжүүлгээ хийлгээгүй, бичиг баримт байхгүй	6.5	-	5.4
Буцаж нүүнэ, бүрмөсөн суурьших эсэхээ шийдээгүй	3.2	16.7	5.4
Бүгд	100.0	100.0	100.0

Харин Заамар суманд бичил уурхай эрхэлж буй иргэд тус суманд оршин суугчаар бүртгүүлэх хүсэлт гаргадаг ч орон нутгийн захиргаа иргэний бүртгэл хийхээс татгалздаг төдийгүй буцаж нүүхийг шаарддаг байна.

Жишээ 3.1

5280 хүн амтай. Жилдээ 100-аад хүн нааш цаашаа шилждэг. Заамар сумын хүн амын тал хувь нь Хайлааст багт байдаг. Манайд бүртгэлгүй хэрнээ суурьшаад байгаа 1000-аад хүн бий.

(Ганцаарчилсан ярилцлага, Заамар сумын засаг захиргааны байгууллагын удирдах ажилтан)

Тухайн орон нутгаас хасалтаа хийлгээд шилжээд ирэнгүүт энд бүртгэл хийхгүй байгаа. Ямар ч бичиг баримтгүй, бүртгэлгүй болчихоод байна.

(Ганцаарчилсан ярилцлага, Заамар сум, бичил уурхайчин)

2010 онд явуулын 1000 хүн тоологдсон. Бичил уурхайчид харъяалах сум орон нутгаасаа хасалтаа хийлгэлгүй ирдэг нь хүндрэл учруулдаг.

(Бүлгийн ярилцлага, Уянга сумын Засаг даргын тамгын газрын ажилтан)

Ганцаарчилсан ярилцлагад хамрагдсан орон нутгийн удирдах ажилтнууд шилжин ирж бүртгэлгүй суурьшсан иргэдийн дийлэнх нь ХАМО иргэд байдгийг тэмдэглэсэн. Судалгаанд хамрагдсан сумдын удирдлагууд явуулын хүн амын шилжилт хөдөлгөөнтэй холбоотойгоор байгаль орчин, сургууль, эмнэлгийн ажилтнуудын ажлын ачаалал ихэссэн гэдэг шалтгаанаар ХАМО иргэдийг оршин суугчаар бүртгэхээс татгалздаг нь Монгол Улсын иргэн улсынхаа нутаг дэвсгэрт чөлөөтэй зорчих, түр буюу байнга оршин суух газраа сонгох Үндсэн хуулиар олгогдсон эрхээ эдэлж чадахгүйд хүргэж байна. Оршин суух бүртгэлгүй ХАМО иргэд нийгмийн болон эрүүл мэндийн тусламж үйлчилгээг авах эрхээ эдэлж чадахгүйд хүрч байгаа олон жишээ баримтуудыг судалгаанд оролцогчид хэлж байсныг дараах жишээнээс харж болно.

Жишээ 3.2

Бид орон нутгаас эмнэлгийн үйлчилгээ авч эрүүл мэндийн үзлэгт хамрагдаж байгаагүй. Харъяалалтай, бүртгэлтэй газраа үзүүл, эм тариа хүрэлцэхгүй байна гэдэг. Эрүүл мэндийн дэвтэргүй бол үздэггүй. Нэр бүхий компанийн харуул хамгаалалтын ажилтан Ж эмэгтэйчүүдийг хэл амаар доромжилж, эрэгтэйчүүдийг зоддог. Би шороо угааж байгаад 2011 оны 4-р сард компанийн хамгаалалтын албаныханд зодуулж, 2 шүдээ хугалуулсан. Зодуураас болж гэртээ 10 хоног орноосоо босож чадахгүй хэвтэрт байхдаатүргэн дуудаад ирэхгүй болохоор бид өөрсдөө унаа олж эмнэлэгт очиход “аналгин” гэдэг эм өгсөн. Компанийн хамгаалалтын албанаас эмчилгээний нөхөн төлбөр шаардахад “Шороо угааж 2 шүднийхээ мөнгийг ол” гэж доромжилсон. Би энэ хүмүүст их гомдолтой байна. Энэ талаар цагдаад мэдэгдэж өргөдөл өгсөн боловч зодсон хамгаалагчийг компани ажлаас нь халаад явуулсан байсан тул эзэн олдоогүй гэдгээр энэ хэрэг одоо хүртэл шийдэгдээгүй. Эмнэлгийн тусламж үзүүлэхдээ хойрго ханддаг, биднийг үзэх дургүй, бидэнд хандах эмч нарын хандлага муу, өөрсдийнх нь хохь гэдэг. Өө муухай нинжа нар байна гэдэг.

(Уянга сум, Эрэгтэйчүүдийн бүлгийн ярилцлага)

Нинжа нар зодуулсан, сковдуулсан, хутгалуулсан байдалтай ирдэг. Эрүүл мэндийн даатгалгүй ч зодуулсан, дарагдсан хүмүүст эмнэлгийн тусламж үзүүлж байсан.

(Уянга сум, бүлгийн ярилцлага, эмнэлгийн ажилтнуудын төлөөлөл)

Одоогоор бичил уурхай эрхлэгчид хаана, хэнд харъяалагдахаа мэдэхгүй, оршин суух газраа сонгох эрхгүй байгаа нь цаашлаад эрүүл мэнд, нийгмийн тусламж үйлчилгээ авах эрхүүдээ эдэлж чадахгүйд хүргэж байна. Ихэнх бичил уурхай эрхлэгчид нийгмийн болон эрүүл мэндийн даатгалд хамрагдаж чадаагүй байгаа нь бичил уурхай эрхлэгчид зохион байгуулалтад орж чадаагүй байгаатай холбоотой.

Хэдийгээр Заамар суманд бичил уурхайг дагасан хүн амын шилжих хөдөлгөөний урсгал нь тус сумын иргэдэд үзүүлэх бүх төрлийн үйлчилгээнд дарамт үзүүлж байх талтай ч бичил уурхай эрхэлж байгаа бүртгэлгүй иргэд Үндсэн хуулиар олгогдсон түр буюу байнга оршин суух эрхээ аливаа ялгаварлан гадуурхалгүйгээр адил тэгш эдлэхэд орон нутгийн захиргааны байгууллагууд хуульд заасан үүргээ биелүүлж ажиллах шаардлагатай байна.

3.2 Бичил уурхай эрхлэгчдийн хүрэлцээтэй түвшинд аж төрөх, өмчлөх эрхийн хэрэгжилт

3.2.1 Хувиараа ашигт малтмал олборлох үйл ажиллагаа, аюулгүй байдал

1997 онд “Алт” хөтөлбөр хэрэгжиж эхэлснээс хойш уул уурхайн салбар манай улсын эдийн засгийн тэргүүлэх салбар болж эрчимтэй хөгжсөн. 1998 оноос уул уурхайн салбарт ажиллах хүчний нэлээдгүй хэсгийг шингээсэн албан бус уурхайн салбар буюу бичил уурхайн үйл ажиллагаа эрчимжиж ажиллагсдын тоо 100.000-д хүрч байсныг 2007 оны “Хүний хөгжлийн илтгэл”-д дурдсан байдаг. Тухайн үед Уянга сумын Өлтийн уурхайд 10000 гаруй гар аргаар алт олборлогчид ажиллаж байсан гэж судалгаануудад дүгнэжээ.

- Өнөөдөр Уянга, Заамар сумдын иргэдийн 70 гаруй хувь нь хувиараа алт олборлож амьжиргаагаа залгуулж байна. Иргэдийн үзэж байгаагаар сум орон нутагт ажлын байр байхгүй, нас хүйсээр ялгаварлаж ажилд авдаггүй, амьдралын бололцоогүй, зуданд малаа барсан, оюутан хүүхдийн сургалтын төлбөрийг төлөхийн тулд аргагүйн эрхэнд аюултай үйл ажиллагаа эрхлэх сонголт хийхэд хүрч байна. ХАМО иргэд бидэнд үүнээс өөр сонголт байхгүй, амь насаараа дэнчин тавьж үр хүүхдийнхээ төлөө ажиллана, цаашид ч бичил уурхайн үйл ажиллагаа эрхэлнэ гэж үзэж байна.

Судалгаанд оролцсон ХАМО иргэдийн дээд тал нь 8-10 жил доод тал нь хоёр жил бичил уурхайгаар ашигт малтмал олборлож байна. Ажилласан жилийг нь авч үзвэл судалгаанд хамрагдсан хоёр хүн тутмын нэг нь 6 болон түүнээс дээш жил бичил уурхайд ажиллаж байгаа бөгөөд үүнээс өөрөөр ажиллах, амьдрах ямар ч арга байхгүй, ажлын байр байхгүй тул амин зуулгаа залгуулахын тулд аминд халтай замыг сонгосон хэмээн хариулж байлаа. Бичил уурхай эрхлэгчдийн дийлэнх нь биднийг төрөөс анхаарч, тусалж дэмждэггүй “хаягдсан, шоовдорлогдсон хүмүүс, өөрсдөө ажлын байраа олж, амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлаа хангадаг гэж үзэж байгаа нь нийтлэг ажиглагдаж байлаа. Түүнчлэн Уянга, Заамар сумдад ажиллаж байгаа бичил уурхай эрхлэгчдийн дотор төрийн байгууллага, хувийн салбарт ажилладаг болон огт ажилгүй, эсхүл тогтмол ажил эрхэлдэггүй иргэд нийт судалгаанд оролцогчдын 36.3 хувийг эзэлж байна. (Хүснэгт 3.3)

Хүснэгт 3.3 Давхар ажил эрхэлдэг бичил уурхайчдын тоо

Сонгосон үзүүлэлтээр	Судалгаанд хамрагдсан газар		Бүгд
	Уянга	Заамар	
Төрийн байгууллагад	-	4	4
Хувийн хэвшилд	3	8	11
Хөлсөөр буюу олдсон ажлаа хийдэг	5	14	19
Мал малладаг	20	3	23
Ажилгүй	10	15	25
Бүгд	38	44	82

Дээрх хүснэгтээс харахад Уянга сумын Өлтийн хөндийд нутагладаг малчид МАА-гаар эрхлэхийн сацуу бичил уурхайд давхар ажилладаг байна.

Орон нутгийн удирдлагуудын өгсөн мэдээллээр одоогийн байдлаар Уянга сумын Өлтийн уурхайд 200 орчим, Заамарын уурхайд нөхөрлөлийн 50 гишүүн, бүртгэлгүй 560, нийт 610 хүн хувиараа ашигт малтмал олборлож амьжиргаагаа залгуулж байна гэсэн билээ. 10000 “нинжа” ажиллаж байсан үетэй харьцуулбал бичил уурхай эрхлэгчдийн тоо эрс цөөрснийг орон нутгийн удирдлагууд тэмдэглэж байсан бөгөөд алтны гарц багассантай холбоотойгоор нинжа нар Сэлэнгэ, Баянхонгор зэрэг аймгуудын нутаг дэвсгэр дэх бичил уурхай руу шилжин суурьшсан гэж хариулж байв. Бичил уурхай эрхлэгчид хаана олборлох үйл ажиллагаа явуулах боломжтой байна тухайн орон нутаг руу нүүдэллэж байна.

Бичил уурхайн салбарт төрийн бодлогыг хэрэгжүүлэх үүрэг нь тухайн орон нутгийн засаг захиргааны нэгжид ногддог. Энэ утгаараа бичил уурхай эрхлэгчдийг орон нутгийн засаг захиргаа нэн тэргүүнд анхаарах ёстой. Гэтэл орон нутгийн засаг захиргаа нь хувиараа алт олборлож өөртөө ажлын байр бий болгон амьдралаа авч яваа иргэдийг хуулийн хүрээнд дэмжихээсээ илүүтэйгээр торгож шийтгэх, хөөх, ачлага хийх, багаж хэрэгслийг нь хурааж авах зэргээр алтны компаниудын эрх ашигт нийцсэн арга хэмжээг түлхүү авч хэрэгжүүлдгийг судалгаанд оролцсон бичил уурхайчид шүүмжилсэн юм. Судалгаанд оролцсон бичил уурхайчдын зарим нь сүүлийн 3-4 жил орон нутгийн удирдлагууд ирж уулзаж байгаагүй, бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журмын хүрээнд зохион байгуулалтад оруулах, ахуй амьдралынх нь талаар харилцан ярилцаж, санал бодлыг нь сонсож байсан тохиолдол огт байхгүй гэлээ. Бүлгийн хэлэлцүүлэгт оролцсон бичил уурхайчид “Эрэл” компанийн үед бичил уурхайчид тус компанитай зохицоод ажилладаг байсан бол одоо орон нутгийн удирдлагууд алттай газраа “техниктэй нинжа” нар буюу жижиг компани, хувь хүмүүст өгөх сонирхолтой, эдгээр нинжа нарын ихэнх нь эрх мэдэлтнүүдийн хамаатан садан, танил талын хүрээллийнхэн болсон гэсэн мэдээллийг өгч байсан юм.

Ялангуяа Уянга сумын Өлтийн уурхайд үйл ажиллагаа явуулж байгаа алт олборлодог компани, аж ахуйн нэгж байгууллагууд болон бичил уурхай эрхлэгчдийн хооронд байнга зөрчил маргаан гарч, улмаар хүний эрхийг зөрчих, зарим тохиолдолд хүний амьд явах, эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхэд нь хүртэл халдсан тохиолдол цөөнгүй гарч байна. Хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй эсэх нь тодорхойгүй, хэний эзэмшлийн, хичнээн компани, хаана, ямар (олборлолтын болон нөхөн сэргээлийн) үйл ажиллагаа явуулж байгаа нь ойлгомжгүй, бичил уурхай эрхлэгчид, орон нутгийн иргэд, малчдад энэ талаарх мэдээлэл байхгүй байгаа нь уул уурхайн салбарт хүний эрх зөрчигдөхөд мөн нөлөөлж байна. Уул уурхайн олборлох салбарын ил тод байдлыг хангахад гол үүрэгтэй орон нутгийн удирдлага нь ч энэ талын мэдээллийг иргэддээ огт хүргэдэггүй, хүргэх хүсэл эрмэлзлэлгүй байна гэж хэлэхэд хилсдэхгүй юм.

Тухайлбал, чанарын судалгаанд хамрагдсан бичил уурхайчдын өгсөн мэдээллээр хаанахын, хэний уурхай болох нь мэдэгдэхгүй Өлтийн хөндийд хувиараа алт олборлогч хувь хүмүүс, компаниудын харуул хамгаалалтын ажилчид компанийн талбайд алт олборлолоо гэдэг үндэслэлээр хөөх, зодож цохих, нохой тавих зэргээр ХАМО иргэдийн эрх чөлөөнд дураараа халддаг явдал жирийн үзэгдэл болжээ. Тэрчлэн орон нутгийн удирдлагууд Өлтийн уурхай нь “урт нэртэй хууль”-д хамрагдсанаар уул уурхайн компаниудын үйл ажиллагаа зогссон гэсэн мэдээллийг өгч байхад бичил уурхай эрхлэгчид, алт олборлож байгаа компаниуд одоог хүртэл үйл ажиллагаа явуулсаар байгааг хэлж байлаа.

Жишээ 3.3

Урьд нь нэг эзэнтэй байхад бид уурхай идээд хаячихсан газарт орж үлдэгдлийг нь олборлодог байсан. Уянгын Засаг дарга нинжа нарыг хөөнө гэж ярьдаг, Өлтийн уурхайн газрыг хувь хүмүүс, компаниуд хувааж авснаар бид ажил хийж амьдрах аргагүй болж байна. Компаниудын харуул хамгаалалт ажилтнууд манай газраас зайл гэж хөөдөг, нохой тавьж хөөдөг. Аргагүйн эрхэнд бид шөнө сэмхэн орж ухдаг. Нэг удаа Ж гэж хүнд 6 нүхний 120000 төгрөг өгч байж 6 нүх ухсан. Бид атга шороогоор амиа зогоож амьдарч байна. Бид нохойноос дор үзэгдэж байна. Төр засгаас ч, орон нутгийн засаг захиргаанаас ч биднийг гэх хүн байхгүй байна.

(Бүлгийн ярилцлага, Уянга сум, бичил уурхай эрхлэгч иргэд)

Уянга сумын бичил уурхайтай харьцуулахад Заамарын алтны уурхайд бичил уурхайгаар ашигт малтмал олборлогч иргэд “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам”-аар зохицуулагдсан нөхөрлөлийн зохион байгуулалтад орж эхэлжээ. .

Уянга сумын бичил уурхай эрхлэгч иргэд “нөхөрлөл”-ийн журмаар бичил уурхайн үйл ажиллагаа явуулах сонирхолтой боловч журамд зааснаар тухайн орон нутагт оршин суугчаар бүртгүүлсэн байхыг шаардаж буй нь нөхөрлөлийн зохион байгуулалтад ороход нь хүндрэл учруулж байна. Орон нутгийн удирдлага ч Уянга сумын иргэнээр бүртгүүлээгүй гэдгээр шалтаглан “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам”-ын хэрэгжилтийг хангаж ажиллахад хойрго хандаж байна хэмээн бичил уурхай эрхлэгчид үзэж байна.

Матриц 3.1 Судалгаанд хамрагдсан бичил уурхай эрхлэгч иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн нөхцөл байдал

	Уянгын уурхай	Заамарын уурхай
Бүлэг, нөхөрлөлийн зохион байгуулалт	Байхгүй	Байгаа
Хөдөлмөрөө хоршиж буй хэлбэр	Байхгүй	Байгаа
Төрийн бус байгууллага	Байхгүй	Байгаа
Бичил уурхайчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж буй орон нутгийн захиргааны байгууллагын дэмжлэг	Байхгүй	Дэмждэг
Журмын хэрэгжилт	Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газар ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор уг журмыг хэрэгжүүлэх боломжгүй байгаа	Хэрэгжиж эхэлж байгаа

Заамар суманд уул уурхайн 17 компани үйл ажиллагаа явуулж байгаагаас зөвхөн “Мондулаан” ХХК нь гурван талт гэрээ байгуулж нийт 50 орчим бичил уурхай эрхлэгчдэд олборлолт явуулах эрх олгожээ. “Мондулаан” ХХК нь ХАМО иргэдтэй гэрээ байгуулж ажилласнаар тус компанийн ашиглалтын талбай руу хулгайгаар нэвтрэх, гэмтэх, бэртэх, осолдох явдал буурсан, компани, ХАМО иргэдийн хоорондын зөрчил маргаан багасчээ. Бусад 16 компанийн хувьд ХАМО иргэдтэй гэрээ байгуулж ажиллах саналыг огт хүлээж авдаггүй байна. Орон нутгийн захиргаа, дарга нарын хувийн үнэлэмж, ашиг сонирголоос шалтгаалж бичил уурхайн үйл ажиллагааг зохицуулсан журам хэрэгжихэд гол саад болж байна. Жишээ нь, Заамар сумын Хайлааст багийн Засаг даргын өгсөн мэдээллээр уг

журмаар 600 гаруй иргэн нөхөрлөлийн зохион байгуулалтаар ажиллах боломжтой, ХАМО иргэдтэй гурвалсан гэрээгээр ажиллах бололцоотой 6 уурхай байгаа боловч сумын удирдлагууд дэмжихгүй байгаагаас шалтгаалж бүртгэлгүй ажилласан хэвээр байгааг шүүмжилсэн юм.

Судалгааны явцад анхаарал татсан ноцтой асуудал бол бичил уурхайн салбарт насанд хүрээгүй хүүхдийн хөдөлмөрийг ашигласаар байгаа нь судалгаанд оролцогчдын дотор олборлолт хийдэг насанд хүрээгүй 4 хүүхэд байлаа. Чанарын судалгаанд оролцсон Уянга сумын ХАМО өрх бүр сургуулийн насны сургууль завсардсан 1-2 хүүхэдтэй, амьдралын бололцоогүйгээс тусад орсон нь аав ээжийн хамт “шороо угаадаг”¹ бол арай бага нь дүү нараа хараад гэртээ үлддэг гэж хариулжээ. Эндээс харахад хүүхдийн үндсэн эрхүүдийн нэг болох сурч боловсрох эрх зөрчигдсөөр байна. Хүүхдийн эрхийг хангаж, хамгаалахад гол үүрэгтэй институциуд болох сургууль, боловсрол, орон нутгийн захиргааны байгууллагууд тухайн орон нутагт харъяалалгүй, бүртгэлгүй бичил уурхай эрхэлдэг өрхийн сургуулийн насны сургууль завсардсан хүүхдүүдийн сурч боловсрох эрхийг хангах арга хэмжээг хэрэгжүүлэхэд анхаарал тавихгүй байгааг илтгэж байна. Бичил уурхайд эцэг эхийн хамт ашигт малтмал олборлож байгаа, мөн хамт амьдарч байгаа хүүхдүүдийн сурч боловсрох эрхээс гадна эрүүл мэндээ хамгаалуулах, эрүүл аюулгүй орчинд аж төрөх, хөгжих эрхүүд давхар зөрчигдсөөр байна. Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журмын 3.5-т сумын Засаг дарга нь “Бичил уурхай эрхлэгчдэд эрүүл мэндийн болон нийгмийн халамжийн үйлчилгээ үзүүлэх, хүүхдийг нь сургууль, цэцэрлэгт хамруулах арга хэмжээ авах” үүргийг хүлээнэ гэж заасан ч хэрэгжилт нь туйлын хангалтгүй байгааг судалгааны дүн харуулж байна.

Бичил уурхайд хүүхдийн эрх зөрчигдөж байгаа асуудлаар орон нутгийн удирдлагууд бичил уурхай эрхлэгч иргэдийн сургуулийн насны хүүхэд сургууль завсардаж байгаагийн шалтгааныг тэд сургуульд авчирч өгдөггүйтэй холбон тайлбарлахын зэрэгцээ жилээс жилд тэвчишгүй хөдөлмөр эрхэлж байгаа хүүхдийн тоо буурч байгаа гэж үзэж байгаа ч тухайн орон нутагт энэ талаарх статистик мэдээлэл хангалтгүй байна.

Жишээ 3.4

Би 1.4 настай, 2 настай, 6 настай, 12 настай, 16 настай, 18 настай 6 хүүхэдтэй. 12 настай охин маань сургуульд суралцаж байхдаа өвчний улмаас хавагнан таарах хувцасгүйгээс хүүхдүүд “Тарган, бүдүүн “ гэж шоглоод аргагүйн эрхэнд 2-р ангиасаа сургуулиас гарсан. Одоо өвчтэй охин маань 3 дүүгээ хараад гэртээ байдаг. Мөнгө төгрөгний боломжгүйгээс эмнэлэгт эмчлүүлж чаддаггүй. 16 настай хүү дүү нараа тэжээх, амьдралд нэмэр болохын тулд 3-р анги төгсөөд сургуулиас гарсан. Одоо надад тусалж шороо угаадаг. Том хүү маань 18 настай. Өмнөговь аймаг руу ажил олж хийхээр сарын өмнө явсан. Ажил олж чадсан эсэхийг мэдэхгүй байна, одоо хүртэл сураг чимээгүй байна.

(Бүлгийн ярилцлага, Уянга сум, Бичил уурхай эрхлэгч эмэгтэйчүүд)

Т нь эгчийнхээ гэр бүлтэй хамт амьдардаг. Тэрээр 11 настай гэх боловч төрсөн эгч нь түүнийг 14 настай гэж хэлж байлаа. 14 настай ч давжаа биетэй, Уянгад 2 настайдаа ирсэн, 6 жилийн өмнө ээж нь нас барсан байна. Т нь сургууль, цэцэрлэгт хамрагдаж байгаагүй, бичиг үсэггүй, хэл ярианы хөгжил муутай. Шороо угааж алт олборлох ажлаа “хэцүү биш, гоё” гэж хэлж байлаа. Том болоод ямар хүн болох вэ? Юу хүсэж мөрөөддөг вэ гэж асуухад хариулсангүй.

(Ганцаарчилсан ярилцлага, Уянга сум, 11 настай эрэгтэй)


Дээрх жишээ баримтаас харахад амьдралын аргагүй нөхцөл байдлын улмаас хүүхэд сурч боловсрох, өсч хөгжих насандаа хүнд хүчир аюултай хөдөлмөр эрхэлж гэр бүлдээ тус нэмэр болох сонголтыг хийж байна.

¹ Бичил уурхайчдын хэлснээр

3.2.2 Амьжиргааны түвшний хүрэлцээтэй байдал

Бичил уурхайчид аюултай, эрсдэлтэй хүнд хөдөлмөр эрхэлж, олсон орлогоороо гэр бүл, үр хүүхдийнхээ өдөр тутмын хоол хүнс, хувцас хунар болон оюутан хүүхдийн сургалтын төлбөрийг төлөхөд зарцуулдаг байна.

Бүлгийн ярилцлагад оролцсон ХАМО иргэд өдөрт дунджаар 10000-20000 орчим төгрөгийн орлого олдог гэсэн бол асуулга судалгаагаар бичил уурхайд ашигт малтмал олборлож олсон орлого нь амьдрал ахуйд нь хүрэлцдэг эсэх, бичил уурхай эрхэлснээр амьжиргаанд нь гарсан өөрчлөлтийг тодруулсан юм.



Уянга сумаас судалгаанд хамрагдсан хоёр хүн тутмын нэг нь амьжиргааны түвшинд ямар нэгэн өөрчлөлт гараагүй, Заамар сумаас судалгаанд хамрагдсан хоёр хүн тутмын нэг нь амьдрал ахуй, орлого нэмэгдсэн гэж тус тус үнэлжээ. Амьдрал ахуй дээрдэх биш харин ч дордсон гэж хариулагчдын дотор Уянгын суманд бичил уурхай эрхлэгчдийн эзлэх хувийн жин илүү байлаа. (Зураг 3.2) Уянга суманд ажиллаж байгаа бичил уурхайчдын дийлэнх нь өдөр тутмын амьжиргаагаа залгуулж байгаа бол Заамар суманд бичил уурхай эрхлэгчдийн хувьд өдөр тутмын амьдралын хэрэгцээгээ хангахаас гадна хуримтлал үүсгэж, удаан эдэлгээт зүйлс, машин унаатай болж амьдрал ахуй нь дээшилсэн байна.

Жишээ 3.5

Жижиг компаниуд, дарга нар Өлтийн уурхайг хувааж авснаас хойш амьдрах аргагүй болж, бидний ашиг орлого ч багассан. Аргагүйн эрхэнд компаниудын газар руу орж ажиллахын тулд нэг цаг тутамд 10000 мөнгө төгрөг, архи, утасны нэгж өгч байж шөнө орж ажилладаг. Хоол хүнс, хэрэгцээт зүйлээ зээлээр аваад шороонд явж ирсний дараа төлдөг.

(Бүлгийн ярилцлага, Уянга сум, Бичил уурхай эрхлэгчид)

Хүмүүс алт угаагаад ахуй амьдрал нь илт дээшилж байгаа нь харагддаг. Манай энд алтанд явдаг хүмүүсийн ихэнх нь машинтай.

(Ганцаарчилсан ярилцлага, Заамар сум, ТББ-ын тэргүүн)

Эрдэс баялаг, эрчим хүчний яам 2011 оны эцэст “Бичил уурхайг 2015 он хүртэл дэд хөтөлбөрийнхөгжүүлэх” дэд хөтөлбөрийн биелэлтийг дүгнэсэн баримт бичигт хувиараа ашигт малтмал олборлогчид холбогдох хууль тогтоомжийн хүрээнд нөхөрлөлийн зохион байгуулалтад орж орон нутагтай гэрээ байгуулан орон нутгийн бичил уурхайн

зориулалтаар тусгай хэрэгцээнд авсан газарт олборлолт явуулснаар бичил уурхайчид тогтмол орлоготой, баталгаатай ажлын байраар хангагдаж, тогтвортой ажиллаж нийгмийн болон байгаль орчны хариуцлагатай, эдийн засгийн үр ашигтай үйл ажиллагаа явуулах нөхцөл бүрдэж байна гэжээ. Харин бичил уурхай эрхлэгчид олноороо үйл ажиллагаа явуулж байгаа Уянга, Заамар суманд дэд хөтөлбөр хангалтгүй хэрэгжилттэй байгааг судалгааны дүн харуулж байна.

3.2.3 Бичил уурхай эрхлэгчдийн газар ашиглах, эзэмших, өмчлөх эрхийн эрхийн хэрэгжилт

Судалгааны үеэр Уянга суманд 8, Заамар суманд 17 уул уурхайн компани үйл ажиллагаа явуулж байв. Бичил уурхай эрхлэгч иргэд, уул уурхайн компаниудын хооронд ашиглалт явуулж байгаа газраа булаалдах зөрчил маргаан өдөр бүр гарч байгаа нь судалгаагаар ажиглагдаж байлаа. Ялангуяа дээрх нөхцөл байдал Уянга сумын Өлтийн уурхайд өдөр бүр тохиолддогийг бичил уурхай эрхлэгчид, орон нутгийн захиргааны ажилтнууд дурдаж байсан билээ.

- Бичил уурхай эрхлэгч иргэдийн үзэж байгаагаар уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа ямар ААНБ, хувь хүн байгаа, ашиглалтын лицензийн тоо, эдгээр лицензийг эзэмшиж байгаа ААНБ-ууд, уурхайн зориулалтаар ашиглаж байгаа газрын хэмжээ, хэдэн жилээр ашигладаг, ашиглалтын хугацаа дууссан, сунгасан эсэх, дамжуулан зарсан, худалдан авсан ААНБ, хувь хүн, нөхөн сэргээлт хийх зөвшөөрлийг хаанаас өгдөг, хичнээн компани нөхөн сэргээлт хийх зөвшөөрөл авсан, нөхөн сэргээлт хийх хугацаа, орон нутгийн иргэд, захиргааны байгууллагын хуулиар олгогдсон эрх үүрэг, хариуцлага зэрэг тодорхой мэдээлэл иргэд, бичил уурхай эрхлэгчид, харуул хамгаалалтын ажилтнуудад хүрдэггүйгээс зөрчил маргаан гарах, газар нутгаа булаалдах, үүнээс улбаалан хүний эрхийн ноцтой зөрчлүүд гарахад нөлөөлж байна.

Хэдийгээр АМГ-ын цахим хуудсанд ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн талаарх мэдээлэл ил тод тавигддаг ч төв суурин газраас алслагдмал газарт үйл ажиллагаа явуулдаг бичил уурхай эрхлэгчдийн хувьд энэ талын мэдээллийг олж авахад хүндрэлтэй байна.

Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журмаас:

Бичил уурхай эрхлэхийн тулд иргэд тухайн орон нутагтаа бүртгүүлж, бүртгэгдээгүй нөхөрлөлийн зохион байгуулалтад орсон байна. Нөхөрлөл нь таваас цөөнгүй гишүүнтэй байхын зэрэгцээ ижил төрлийн үйл ажиллагаа явуулж буй өөр нөхөрлөлд гишүүн байхыг хоригложээ. Бичил уурхай эрхлэх нөхөрлөл нь ашигт малтмал олборлох гэрээ байгуулах тухай өргөдөлдөө нөхөрлөлийн нэр, ахлагч буюу эрх бүхий төлөөлөгч болон гишүүдийн нэр, хаяг, талбайн байршлын зураг, олборлох ашигт малтмалын төрлийг заавал тусгаж, иргэний үнэмлэх, гишүүдийн хамтран ажиллах гэрээ, татвар төлөгчийн гэрчилгээ, эрүүл мэнд, нийгмийн даатгалын дэвтрийн хуулбар зэрэг бичиг баримтуудыг бүрдүүлж сум, дүүргийн Засаг даргад хүргүүлэх ёстой.

Сум, дүүргийн Засаг дарга өргөдлийг хүлээн авснаас хойш ажлын 10 хоногт багтаан судалж, шаардлага хангасан гэж үзвэл гэрээ байгуулна.

Засгийн газрын 2010 оны 308 дугаар тогтоолоор батлагдсан “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам”-д зааснаар бичил уурхайгаар ашигт малтмал олборлох иргэд бүртгэгдээгүй нөхөрлөлийн зохион байгуулалтад орох бөгөөд нөхөрлөлийн гишүүн нь тухайн орон нутагт оршин суугчаар бүртгүүлсэн байхыг шаарддаг. Ашигт малтмалын

тухай, Газрын тухай хуульд орон нутаг Ашигт малтмалын газраас гаргасан дүгнэлтийг үндэслэн бичил уурхайн зориулалтаар орон нутгийн тусгай хэрэгцээнд газар авч бичил уурхайгаар ашигт малтмал олборлох газрын асуудлыг шийдвэрлэхээр зохицуулсан. Уянга сумын хувьд бичил уурхай эрхлэгч иргэдийн дийлэнх нь бүртгэлгүй иргэд тул нөхөрлөлийн журмаар үйл ажиллагаа явуулах эрх нь дээрх хууль, журмаар бололцоогүй болж байна. Бичил уурхай эрхлэгчдийн өгсөн мэдээллээр нөхөрлөл үүсгэн байгуулах, бүртгэх асуудлыг тухайн сумын Засаг дарга шийддэг нь ашиг сонирхлын зөрчил, авилгатай холбоотой сөрөг асуудлыг бий болгодог байна.

- **Бичил уурхай эрхлэгчид хувиараа ашигт малтмал олборлож байгаа тухайн орон нутагтаа оршин суугчийн бүртгэлгүйгээс шалтгаалан “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам” дахь нөхөрлөлийн зохион байгуулалтаар бичил уурхай эрхлэх эрхээ эдэлж чадахгүй байна. Иймд бичил уурхай эрхлэгч иргэд Үндсэн хуулиар баталгаажсан газар эзэмших, ашиглах, өмчлөх эрхээ эдлэх аргагүй болж байна.**

Хэдийгээр бичил уурхайн эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлж байгаа ч хорь гаруй жилийн турш албан бус бүртгэлтэй байсан бичил уурхайчдийн иргэнийхээ хувьд эдлэх ёстой эрх, тодруулбал, оршин суух газраа чөлөөтэй сонгох эрхээ эдэлж чадахгүй байсаар байгаа нь цаашлаад газар эзэмших, ашиглах, өмчлөх эрхээ мөн эдэлж чадахгүйд хүргэж байна.

Жишээ 3.6

Бид нөхөрлөлийн хэлбэрт орж ажиллъя гэхээр заавал Уянга сумын харьяат байх ёстой гэдэг. Бид бүгдээрээ шахуу аймгийн төвөөс ирсэн хүмүүс байдаг. Харин “АУМ” компанийн хажууд байрлаж байгаа 50-иад айлд 5 нүх ухахыг зөвшөөрсөн. Эдгээр айлууд нь Бүргэдэй гэдэг газарт байрладаг. Гэтэл тэр газар нь доошоо маш их цэвдэгтэй газар, хэрэв нэг нүх ухаад тэндээс юу ч гараагүй тохиолдолд 1-2 сая төгрөгийн өрөнд унадаг. Багажаар ажилладаг учраас байнга бензин хэрэглэдэг.

(Бүлгийн ярилцлага, Уянга сум, Бичил уурхай эрхлэгчид)

Өнөөдөр бичил уурхайн салбарт хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомж нь бичил уурхайгаар ашигт малтмал олборлох иргэн олборлолт явуулах тухайн орон нутагтаа бүртгэлтэй иргэн байхаар зохицуулагдсан тул тухайн орон нутагт бичил уурхай эрхлэхээр бусад аймаг, сум, хотоос ирсэн Монгол Улсын иргэдэд бичил уурхайгаар ашигт малтмал олборлох нөхөрлөл үүсгэн байгуулах, нөхөрлөлийн гишүүнээр элсэх, улмаар тухайн орон нутгаас бүх төрлийн төрийн үйлчилгээ авах эрх нь хаалттай болж байна. Энэ тохиолдолд дийлэнх нь хууль бусаар хувиараа ашигт малтмал олборлох үйл ажиллагаа эрхлэх сонголтыг хийж байна.

Жишээ 3.7

Засгийн газраас гаргасан журмаар нөхөрлөлийн хэлбэрээр бичил уурхай эрхэлж байгаа хүмүүс огт байхгүй. Нэгэнт төр засгаас “урт нэртэй” хууль батлагдсан учраас бид нинжа нарыг дэмжээд нөхөрлөлийн зохион байгуулалтад оруулах ажил хийх шаардлагагүй болчихож байгаа юм.

(Бүлгийн ярилцлага, Уянга сумын засаг захиргааны удирдах ажилтан)

Уянга, Заамар суманд ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшиж байгаа уул уурхайн компаниуд, ААНБ, эзэмшиж байгаа газрын хэмжээ, бусдад шилжүүлсэн тусгай зөвшөөрлийн талаарх мэдээлэл, нөхөрлөл, түүний зохион байгуулалт, бичил уурхайн хууль тогтоомж, нөхөн сэргээлт хийж байгаа компаниудын тухай орон нутгаас гарах боломжтой хуулиар хориглоогүй мэдээллийг иргэд, бичил уурхайчдад ил тод,

нээлттэйгээр мэдээлдэг байх, сумын ЗДТГ-ын мэдээллийн самбарт байрлуулах шаардлагатай байна. Ялангуяа иргэд, бичил уурхайчдад бичил уурхайн талаар сум орон нутгийн баримталж байгаа бодлого шийдвэр, баталсан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх хүрээнд хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаарх мэдээллийг гаргаж тавих нь зүйтэй. Судалгаанд хамрагдсан бичил уурхай эрхлэгч иргэдээс өөрийн эзэмших, өмчлөх газартай эсэхийг тодруулахад нийт судалгаанд оролцогчдын 73.9 хувь нь байхгүй гэжээ. Өөрийн өмчлөлийн газартай гэж хариулагчдын хувьд Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулиар өмчилж авсан хашааны 0.7 га газраа тооцож хариулсан нь нийтлэг байсныг дурдах нь зүйтэй.

Хүснэгт 3.4 Бичил уурхайчид газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн хэрэгжилт

Сонгосон үзүүлэлтээр	Байршлаар		Бүгд
	Уянга сум	Заамар сум	
Эзэмшлийн газартай	31.2	21.4	21.1
Эзэмшлийн газаргүй	68.8	78.6	73.6
Бүгд	100.0	100.0	100.0
Тоо	109	117	226

Уянга сумын хувьд судалгаанд оролцсон малчид өвөлжөө хаваржааны зориулалтаар эзэмшиж буй гэрчилгээтэй газраа өөрийн өмчлөлийн газар гэж ойлгон хариулж байлаа.

- **Орон нутагт бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журмыг хэрэгжилт удаашралтай төдийгүй хувиараа ашигт малтмал олборлогчдыг нөхөрлөлийн зохион байгуулалтад бүрэн шилжүүлэх үүрэг хүлээсэн орон нутгийн удирдлагууд уг журмыг хэрэгжүүлэх хүчин чармайлт, сонирхол бага байгаа нь судалгаагаар ажиглагдаж байлаа.**

Матриц 3.2 Бичил уурхай эрхлэгчдийн газар эзэмших, ашиглах эрхийн хэрэгжилт

Уянгын уурхай	Заамарын уурхай
<ul style="list-style-type: none"> - Сумын Засаг дарга, удирдлагууд хувь хүн, уул уурхайн компаниудад Өлтийн уурхайн газрыг ашиглуулах сонирхолтой - Орон нутгийн удирдлагууд уул уурхайн ашиглагдсан газарт ХАМО иргэдийг нөхөрлөл үүсгэн байгуулах, нөхөрлөлийн гишүүнээр орох үйл ажиллагааг дэмждэггүй Уянга сумын Засаг дарга болон удирдлагууд Өлтийн уурхайн газрыг найз нөхөд, ах дүүгээрээ нийлсэн жижиг уул уурхайн компаниудын нэрээр худалдан авч, газар нутгийг хувааж авсан - Уул уурхайн олон жижиг компаниуд үйл ажиллагаа явуулж байгаа нь байгаль орчинд учруулах хор хөнөөл их - Нинжа нар буюу ХАМО иргэд газар өмчлөх, ашиглах, эзэмших эрхээ эдэлж чадахгүй байна - Хувийн жижиг уул уурхайн компаниуд ашиглалтын лицензтэй эсэх, лиценз нь дууссан, сунгасан эсэх нь тодорхойгүй 	50 бичил уурхайчин нөхөрлөлийн зохион байгуулалтаар бичил уурхайн үйл ажиллагаа явуулж байна.

Иргэдийн үзэж байгаагаар уурхайнуудын ашигласан талбайд бичил уурхайн үйл ажиллагаа явуулахад алтны компаниуд, орон нутгийн удирдлагуудын эсэргүүцэл,

дарамт, айлган сүрдүүлэлт, заналхийлэлтэй байнга тулгардаг байна. Бодит нөхцөл байдалд ХАМО иргэдэд олборлолт явуулах, газар өмчлөх, ашиглах, эзэмших эрх, эрх чөлөө байхгүй байна.

Жишээ 3.8

Уул уурхайн компаниуд цагдаа нарыг их шагнадаг. Ямар нэгэн баяр ёслолоор 500, 600 мянга, 1 сая төгрөг гэх мэтээр шагнадаг. Цагдаа нарыг дуртай цагтаа дуудаж уурхайн талбайгаас нинжа нарыг хөөж гаргуулдаг. Манай багийн бүх айл өрх алтанд явдаг. Алтнаас хамааралгүй айл байна уу гэхэд нэг ч айл байдаггүй. Явахаас ч өөр арга алга байна шүү дээ. Энэ сум, орон нутагт чинь ажлын байр алга.

(Ганцаарчилсан ярилцлага, Заамар сум, Хайлааст багийн Засаг дарга)

Нинжа гэж яригдаад байгаа хүмүүс эрхээ эдлэхдээ хууль тогтоомжид заасан хязгаараасаа давж эдлэх, хууль зөрчих тохиолдол ихээр гаргадаг. Зөвшөөрөлгүй газраас шороо ухна. Тэр шороогоо гол, булаг руу угаана. Газрын хэвлийн тухай хууль, Усны тухай хууль зөрчигдөж байгаа юм. Зөвшөөрөлгүй мод бэлтгэдэг, ан амьтан ихсэхээр тарвага агнана, самар түүнэ. Ингэж явахдаа ой хээрийн түймэр тавих тохиолдол гардаг.

(Бүлгийн ярилцлага, Уянга сумын Байгаль орчны байцаагч)

Ер нь ямар ч тохиолдолд биднийг хууль бус гээд хүнлэг бус харьцдаг. Өнгөрсөн жил уул уурхайн компани улсын баталгаатай зам эвдээд, Туул голын усны гольдролыг өөрчилж уурхайн талбайг хязгаарласан шуудуу ухахад нь бид цагдаагийн байгууллагад мэдэгдэж дуудлага өгсөн гэтэл цагдаа нар ирээд уул уурхайн компанийг торгох биш мэдээлэл өгсөн бидний машины бичиг баримтыг хурааж аваад явсан. Замын цагдаа дэслэгч Борхүү дэлгүүр хоршоонд орж ирээд төрийн цагдаа явж байхад айж эмээсэнгүй гээд дэлгүүрийн бичиг баримт хурааж аваад явдаг. Одоо яаж металл хайгчаа олж авахаа мэдэхгүй байна. Хэрэв хэнд байгаа нь олдвол ямар нэг аргаар мөнгө олж торгууль төлөөд авна. Манай эндхийн байгаль орчны байцаагч, цагдаагийн хүмүүс гар аргаар ашигт малтмал олборлогч хүмүүсийг хүн гэж харахаасаа илүү унасан унаа, багаж хэрэгслээр нь үнэлж ярьдаг. Биднийг эд хөрөнгөнд нь тааруулж торгох мөнгөний хэмжээгээр нь нэрлэдэг. Тухайлбал, машинтай хүнийг 250000, том металл хайгчтай хүнийг 200000, мотоцикльтэй хүнийг 100000, түмпэнтэй хүнийг 5000 төгрөг явж байна гэж ярьдаг.

(Бүлгийн ярилцлага, Заамар сум, Бичил уурхай эрхлэгч иргэд)

3.3 Бичил уурхай эрхлэгчдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхийн хэрэгжилт

Судалгааны дүнгээс харахад бичил уурхай эрхлэгчдийн эрүүл мэндээ хамгаалуулах, эрүүл аюулгүй орчинд амьдрах эрх, хөдөлмөр эрхлэлтийн үеийн аюулгүй байдал үндсэндээ орхигджээ. Бичил уурхайчид, орон нутгийн засаг захиргааны байгууллага, асуудал хариуцсан төрийн байгууллагуудын аль аль нь үүнийг хүлээн зөвшөөрч байгаа ч тэдний зүгээс анхаарал хандуулж авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ хангалтгүй байна.

Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журамд сумын Засаг дарга бичил уурхай эрхлэгчдэд эрүүл мэндийн үйлчилгээнд хамруулах үүрэг хариуцлага хүлээнэ гэж заасан байдаг ч судалгаанд хамрагдсан бичил уурхай эрхлэгчдийн дийлэнх нь эрүүл мэндийн үйлчилгээ авч чадахгүй байгаа нь бичил уурхай эрхлэгчид, орон нутгийн засаг захиргааны удирдлага, төлөөлөлтэй хийсэн бүлгийн ярилцлагын дүнгээр баталгаажиж байна.

Зураг 3.1 Уянга суман дахь Өлтийн уурхайн орчмын орчны нөхцөл байдал



Жишээ 3.9

Судалгааны явцад Өлт хавь орчим хогондоо дарагдсан, бага насны хүүхдүүд хогийн ойр орчим тоглож байгаа дүр зураг харагдаж байлаа. Бие засах газар, хогийн сав байхгүй, жалга, гуунд ил задгай бие засч, хогоо хаяж байгаагаас, эрүүл ахуйн наад захын шаардлагыг хангасан орчинд хувиараа ашигт малтмал олборлогч иргэд амьдарч чадахгүй байгааг илтгэж байна.

(Ажиглалт, Уянга сум, Өлтийн уурхай)

Уянга, Заамар сумын уурхайн болон иргэд хувиараа ашигт малтмал олборлож буй орчны эрүүл ахуй, ариун цэврийн нөхцөл байдлыг ХАМО иргэд, нутгийн иргэд, орон нутгийн захиргааны байгууллагын төлөөлөл зэрэг бичил уурхайн салбарт оролцогч талууд бүгд туйлын хангалтгүй гэж үнэлж байгааг чанарын судалгааны дүн харуулж байна.



Зураг 3.2 Уянгын сумын ХАМО нар гэрийнхээ гадна алт угааж байна

Судлаачид мэдээлэл цуглуулах үеэр бичил уурхай эрхлэгчдийн амьдарч байгаа орчин нөхцөлтэй танилцахад хог хаягдлаа ил задгай хаясан, хогондоо дарагдсан, хогтойгоо хаяа нийлэн амьдарч байгаа дүр зураг ажиглагдаж байлаа. Орон нутгийн удирдлагууд 2010 онд хувиараа ашигт малтмал олборлон амьдарч байгаа иргэдийн оршин суугаа орчинд их цэвэрлэгээ хийж, бие засах 2-3 нүх ухаж, 3 хогийн цэг байгуулж өгсөн гэж хариулсан ч судалгааны мэдээлэл цуглуулах явцад хогийн цэг, бие засах газар огт байхгүй байлаа. Нэг талаас ХАМО иргэд гэрээсээ 3-4 метр хүрэхгүй газарт хогоо ил задгай хаяж орчин тойрноо бохирдуулж байгаа бол

нөгөөталаас орон нутгийн захиргаа бичил уурхай орчмын хогийг зайлуулах арга хэмжээг авдаггүйгээс хур хог овоорчээ. Уул уурхай, бичил уурхайн салбарт үйлчилж буй хууль эрх зүйн орчны хүрээнд сумын Засаг дарга, ИТХ-ын дарга нар бичил уурхай эрхлэгчид эрүүл мэндээ хамгаалуулах, эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөл байдлыг бүрдүүлэх үүрэг хүлээдэг. Гэтэл судалгаанд хамрагдсан оролцогчдын өгсөн мэдээллээс харахад бичил уурхайчдын хувьд эрүүл аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдлоос хамгаалуулах эрх нь зөрчигдөж, өнөөдрийг хүртэл сэтгэл түгшээсэн ноцтой асуудал хэвээр байна.

Жишээ 3.10

Хүн бүр астамтай болох байх. Ногоо ургатал манай баг иймэрхүү шороо шуурсан байдалтай байдаг. Энэ бол уурхайн шороо. Гэрийн бүрээс, эсгий бол даагдахын аргагүй болсон.

(Ганцаарчилсан ярилцлага, Заамар сум, ХАМО иргэд)

Уурхай орчмын эрүүл ахуйн нөхцөл, эрүүл аюулгүй орчинд аж төрөх асуудал бичил уурхай эрхлэгчид, орон нутгийн захиргааны байгууллагын аль аль нь анхаарал хандуулдаггүй асуудал болж хувирчээ. Ялангуяа бага насны хүүхдүүд хог шороон дунд өсч торнин, тоос шороогоор амьсгалж амьдарч байна. Хүүхдийн эрхийг хамгаалах тухай

хуулийн 3-р зүйлийн 2.5-д онцгой болон хүнд нөхцөлд амьдарч байгаа хүүхдийг судлан тогтоож, тэдний эрх ашгийг хамгаалах арга хэмжээг төрийн байгууллагууд хүлээнэ (сум, багийн Засаг дарга нар), 12-р зүйлийн 1-д эцэг эх, асран хамгаалагч нь хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах амьдрах эрүүл саруул, аюулгүй орчин бүрдүүлэх, 11-р зүйлийн 3.2-т багийн Засаг дарга нь хүнд нөхцөлд амьдарч байгаа хүүхдэд тусламж дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулна гэж тус тус заасан байдаг ч эдгээр хуулийн заалтууд бичил уурхайн үйл ажиллагаа явагдаж буй орчинд огт хэрэгжихгүй байна. Хуулийн хэрэгжилтийг хангахад чухал үүрэгтэй субъектууд болох сум, багийн удирдлагууд энэ талаар тодорхой ажил зохион байгуулдаггүй болох нь гар аргаар ашигт малтмал олборлож буй иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх нь 100 хувь хангагдана гэж байхгүй, ийм арга замыг сонгож байгаа нь ХАМО иргэдээс өөрсдөөс нь шууд шалтгаалж байгаа тэдний асуудал, тэднийг хувиараа алт олборлож өөрсдийгөө эрдсэлтэй нөхцөл байдалд оруул гэж хэлээгүй гэх сөрөг хандлага орон нутгийн удирдлагуудын дунд нийтлэг ажиглагдаж байсныг дурьдах нь зүйтэй. Түүнчлэн Үндсэн хууль, Эрүүл мэндийн тухай хуульд Монгол Улсын иргэн эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж үйлчилгээ авах эрхтэй төдийгүй энэхүү үйлчилгээг хүргэх, үзүүлэх ёстой орон нутгийн удирдлага, тангараг өргөсөн эмч нар ХАМО иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, аюулгүй байдлыг хангах тал дээр туйлын хойрго хандаж байна.

- “АУМ” ХХК болон бусад жижиг алтны уурхайн компаниудын харуул хамгаалалтын ажилтнуудад зодуулж, бэртэж гэмтсэн ХАМО иргэдэд хүний амь нас, эрүүл мэндийг хамгаалах үүрэгтэй эмч, эмнэлгийн ажилтнууд нинжа нарын өөрсдийнх нь хохь гэж ханддаг, “муу нинжа нар” гэх зэргээр зодуур хүчирхийлэлд өртсөн дээр нь нэмж ялгаварлан гадуурхаж доромжилдог байна.

ХАМО иргэд эрүүл мэнд, амь насаараа дэнчин тавин аюултай хүнд хөдөлмөр эрхэлж байгаа ажлын нөхцөл байдал болон эрүүл мэндээрээ хохирч байгаа жишээ баримтыг дэлгэж байлаа.

Матриц 3.3 ХАМО иргэдийн эрхэлж буй ажлаас шалтгаалсан өвчлөл, эмч нарын хандлага

	Уянга сум	Заамар сум
ХАМО иргэдийн эрхэлж буй ажил эрхлэлтээс шалтгаалсан өвчин		
Нуруу ууцаар хөшдөг болсон	+	
Бөөр өвддөг	+	
Гар бадайрч өвддөг	+	
Астамтай болсон		+
Хүүхдүүдийн дунд амьсгалын замын өвчлөл нэмэгдсэн		+
Астамтай болсон		+
ХАМО иргэдэд хандах эмч, ажилтнуудын хандлага		
Эмнэлэг нь тоодоггүй	+	
ХАМО иргэдэд хандах эмч нарын хандлага сөрөг (эмч нар хохь чинь, та нарыг хэн нүхэнд хэвт гэсэн юм гэх мэтээр ханддаг)	+	
Эрүүл мэндийн дэвтэргүй бол үздэггүй	+	
Түргэн тусламж дуудаад ирдэггүй (өөрсдөө очиж үзүүлдэг)	+	
Эмнэлгийн тусламж үзүүлэхдээ хойрго ханддаг	+	
Гадны оршин суугчийг үзэхгүй, бүртгэлтэй газраа очиж үзүүл гэдэг	+	

ХАМО иргэдийн талаарх эмч нарын өгсөн ярилцлага	+	
Зодуулсан, хутгалуулсан, дарагдсан, төрөх дөхсөн ХАМО иргэдэд ЭМД харгалзахгүй эмнэлгийн тусламж үзүүлдэг	+	
ДОХ, Сүрье, Бэлгэвч төсөлд хамруулсан	+	
Өлтийн уурхай тоосон дунд байдаг тул харшлын өвчлөл ихэссэн	+	
4 жилийн өмнө шар өвчин гарсан, урьдчилан сэргийлэх арга хэмжээг авдаг	+	
Өлтийн хүүхдүүдийг эрүүл мэндийн үзлэгт хамруулдаг	+	



Зураг 3.3 Уянга сумын ХАМО эмэгтэйчүүд хүйтэн усанд усны гуталтай зогсоод алтаа угааж байна.

ХАМО иргэд хүйтэн усанд усны гуталтай зогсож, чийгтэй, нойтон газар өвдөглөн сууж ажиллах явдал нийтлэг ажиглагдаж байв. Судалгаанд хамрагдсан ХАМО иргэд хөдөлмөрийн хүнд, аюултай нөхцлөөс үүдэлтэй хөл гар, бөөр нуруу, ууц сав өвдөх, тоосны харшил, даралт ихсэх өвчнөөр түгээмэл өвчилж байна. Эмч нар ХАМО иргэдэд таагүй ханддагаас шалтгаалан өвдсөн үедээ эмнэлгийн тусламж авч чаддаггүй тул эм ууж аргалдаг хэмээн ярьж байлаа.

Жишээ 3.11

Бид аль нэг нүхэнд ажиллаж байх үед төрөөс бидний хөдөлмөр хамгааллын талаар ямар ч арга хэмжээ авдаггүй, бид өөрсдөө л аюулгүй байдлаа хангах гэж мэрийцгээдэг. Ууц нуруу байнга өвддөг, үе мөчний өвчтэй болж байгаа. Явган сууж алтаа угаадаг учраас хөл, гарын судас бүдүүрэх өвчин тусч байгаа. Хөлийн судас бүдүүн болсон.

(Бүлгийн ярилцлага, Уянга сумын ХАМО иргэд)

Заамар сумын уурхайн орчимд ус, агаарын бохирдол асуудал болсон бөгөөд тоосжилтоос шалтгаалсан амьсгалын замын өвчнөөр 150 гаруй хүн эмнэлэгт хэвтэхэд 98 нь хүүхэд байжээ. Орон нутгийн захиргааны төлөөллийн хэлсэнчлэн бичил уурхайчдын хувьд эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөл үндсэндээ байхгүй болсныг тэсэрч, дэлбэрэх бодис хэрэглэн 10-20 метрийн туннел ухаж ордог, бичил уурхайн аюултай, эрсдэлтэй хөдөлмөр нь агааргүйдэх, шороонд дарагдах зэрэг эрсдлийг байнга дагуулж байдагтай нь холбон тайлбарлаж байлаа. Түүнээс гадна Туул голын ус хүн, мал уухын аргагүй болтлоо бохирдсон тул иргэд хатуулаг ихтэй усыг унданд хэрэглэж байна. Эндээс харахад бичил уурхай эрхлэгч иргэд төдийгүй тухайн орон нутгийн иргэд цэвэр усаар хангагдах, эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхүүд нь ноцтойгоор зөрчигдөж байгааг судалгааны баримтууд олонтаа харуулж байна.

Судалгаанд хамрагдсан ХАМО иргэдээс гэр бүл, ойр дотны хүмүүс, найз нөхөд болон нутгийн иргэдээс бичил уурхайн үйл ажиллагаатай холбоотойгоор эрүүл мэндээрээ хохирсон, амь насаа алдсан тохиолдол бий эсэх, энэ тохиолдолд эмнэлгийн тусламж үйлчилгээг цаг алдалгүй түргэн шуурхай авч чаддаг эсэхийг тандсаныг дараах хүснэгтэд харуулав.

Хүснэгт 3.5 Бичил уурхайн үйл ажиллагааны улмаас амь нас, эрүүл мэндээр хохирсон хүний тоо ба эмнэлгийн тусламж шуурхай авсан хүний тоо

	Уянга	Заамар	Нийт
Эрүүл мэнд, амь насаараа хохирсон хүний тоо	22	18	40
Эрүүл мэндийн тусламж шуурхай авсан хүний тоо	10	14	24


Дээрх хүснэгтээс харахад бичил уурхайн үйл ажиллагааны улмаас эрүүл мэнд, амь насаараа хохирсон 40 тохиолдлын 24 нь л эмнэлгийн тусламж үйлчилгээг шуурхай авч үлдсэн 16 тохиолдолд нь эмнэлгийн тусламж үйлчилгээг шуурхай авч чадаагүй гэжээ. Энэ нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлэх үүрэг хариуцлага хүлээсэн эмч нар Монгол Улсын иргэн хэн ч байсан эрүүл мэндийн тусламж үйлчилгээг авах эрхийг нь зөрчиж байгааг харуулсан олон жишээ баримтуудын нэг нь болж байгааг харуулж байна.

Жишээ 3.12

Бидний ихэнх нь 35-аас дээш настай, ажилд орьё гэхээр ажлын байр байхгүй, ажил байдаггүй тийм л хүмүүс. Унд хоолныхоо төлөө шороо ухаж байгаад нэг л өдөр хүнд алуулах байх. Уурхайн харуул хамгаалалтынхан болон ажилтнууд нь нүхэн дотор байж байхад дээрээс ирж шороо хийдэг, булдаг.

(Булгийн ярилцлага, Уянга сумын ХАМО иргэд)

Бичил уурхайд хүнд хөдөлмөр эрхэлж, эрүүл мэндээрээ хохирсон тохиолдолд эмнэлгийн тусламж үйлчилгээг шуурхай авч чадаагүйн шалтгааныг тодруулсныг дараах зурагт харуулав.



ХАМО иргэдийн бараг тал хувь нь эмнэлгээс хол газар амьдардаг тул эмнэлгийн тусламж үйлчилгээ авахад хүндрэл учирдаг гэж үзлээ.

Жишээ 3.13

Ноднин компанийн талбай руу 2-3 залуу ороод 2011 онд хууль бусаар алт олборлогчид хоёр нь машинд дайруулж нас барсан. 2011 шороонд дарагдаж амь насаа алдсан, гэмтэж оны 7-р сарын 13-ны орой Т гэдэг хүний бэртсэн тохиолдол гараагүй. 2010 онд 3

уурхай руу 10 гаруй залуу ороод байхад нь усны цистерн машин орж ирээд дайрсан. Санаатай, хөөж дайрсан. 2 хүн газар дээрээ нас барсан. Тэр жолооч 5 жилийн ял авсан.

(Бүлгийн ярилцлага, Заамар сум, ХАМО иргэд)

тохиолдол гарсан. Манай баг эрүүгийн нөхцөл хүнд газар. Жилээс жилд ирж байгаа хүмүүсийн тоо нэмэгдэж байна.

(Бүлгийн ярилцлага, Заамар сум, Цагдаагийн хэлтсийн хэв журмын хэлтсийн дарга)

Түүнчлэн алтны уурхайн харуул хамгаалалтын ажилтнууд хүний эрх, эрх чөлөөнд дураараа халдаж хэвтэрт ортол нь зодох, шүдийг нь хугалах зэргээр бие махбодид нь хүнд бэртэл гэмтэл учруулах зэргээр хүний эрх зөрчсөн хууль бус үйлдэл газар авчээ. Заамар суманд алтны уурхайн ажилтнууд хүний амьд явах эрхэд санаатай халдсан тохиолдол гарч байсныг бүлгийн ярилцлагад хамрагдсан хувиараа ашигт малтмал олборлогчид хэлж байлаа. Тухайлбал, асуулга судалгаагаар бичил уурхайн үйл ажиллагааны улмаас бэртэж гэмтсэн болон амь насаа алдахад хүрсэн шалтгааныг тодруулахад ихэнх нь алтны компаниудын харуул хамгаалалтын ажилтан, цагдаа нарт зодуулж эрүүл мэндээрээ хохирсон, нүх ухаад харуул хамгаалалтын ажилтнуудаас зугтаж яваад шороонд дарагдсан, шороонд дарагдаж нас барсан, алтаа угаадаг нуурын усанд унаж нас барсан жишээ баримтууд олныг хэлж байлаа.

- Уул уурхайн компаниудын харуул хамгаалалтын ажилтнууд ХАМО иргэдийн биед дураараа халдаж зодож, цохихоос гадна уурхайн согтуу жолооч нар ХАМО иргэдийн гэрийг дайрч тэдний амьд явах, эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхэд нь халдах, ажлын байр буюу ухсан нүхэндээ байхад нь дээрээс нь шороо хийж асгах, “амьдаар чинь шороонд булна шүү” гэх мэтээр байнга заналхийлж дарамталсан үйлдэл гаргадаг ажээ. Эдгээр хүний эрхийг зөрчсөн үйлдлүүдийг орон нутгийн удирдлага, цагдаагийн байгууллага төдийлөн авч хэлэлцдэггүй бөгөөд эсрэгээр ХАМО иргэдийг буруутгаж ханддаг байна.



Асуулга судалгаанд хамрагдсан ХАМО иргэдийн 28.8 хувь нь сум, багийн Засаг дарга, цагдаагийн ажилтнууд гар аргаар ашигт малтмал олборлогчдыг хавчиж дарамталдаг, 20.5 хувь нь хувийн уурхайнууд өөрийн эзэмшлийн талбайгаас хөөдөг, хөөлгөдөг, 20.5 хувь нь эрүүл мэндээрээ хохирч байна гэж хариулсан нь хамгийн өндөр давтамжтай үзүүлэлт болж байна.

Дээрх асуулга судалгааны үр дүнг бүлгийн ярилцлагын үр дүн давхар баталгаажуулж байгаа бөгөөд олон жишээ баримтуудыг судалгаанд хамрагдсан оролцогч талууд дэлгэсэн юм. Тухайлбал, бүлгийн ярилцлагад оролцсон Заамар сумын бичил уурхайд ажиллаж буй ХАМО иргэд 2011 онд алтны компанийн ажилтнууд 2 хүний аминд хүрсэн гэсэн бол Заамар сумын цагдаагийн ажилтан тус онд амь насаа алдсан, гэмтэж бэртсэн тохиолдол гараагүй гэсэн мэдээллийг өгсөн болно. Бичил уурхайчид уул уурхайн компанийн эзэмшлийн карьер дундуур явсан, ухсан нүхээ булаагүй гэдгээр шалтаглан бичил уурхай эрхлэгчдийг цохиж зодох, цагдаа нартай нийлж айлган сүрдүүлэх, заналхийлэх, хэл амаар доромжилж дарамтлах явдал байнга гардгийг бүлгийн ярилцлагад оролцогчид хэлж байлаа.

3.4. Бичил уурхай эрхлэгчдийн оролцооны эрхийн хэрэгжилт

Хувиараа ашигт малтмал олборлож байгаа иргэд болон орон нутгийн иргэдийн Үндсэн хуулиар баталгаажсан оролцооны эрхийн хэрэгжилтийг уул уурхайн асуудлаар шийдвэр гаргах үйл явцад оролцож буй байдал, хурал уулзалтад оролцох хэлбэрээр мэдээлэл авч буй байдал, иргэдийн өргөдөл гомдлыг шийдвэрлэсэн байдалд иргэдийн өгч буй үнэлгээнд тулгуурлан тодорхойллоо.

Хүснэгт 3.6 ХАМО иргэдийн уул уурхайн асуудлаарх оролцооны эрхийн хэрэгжилт

	Тоо	Хувь
Орон нутгийн удирдлагад иргэдийн тавьсан өргөдөл гомдлыг шийдвэрлэж буй байдал		
Сайн	11	4.9
Дунд	53	23.5
Тааруу	32	14.2
Маш муу	129	57.1
Мэдэхгүй	1	0.4
Орон нутгийн удирдлага иргэдийн эрх ашгийг хөндсөн шийдвэр гаргахад иргэдийн оролцоог хангаж буй байдал		
Сайн	15	6.6
Дунд	97	42.9
Тааруу	22	9.7
Маш муу	63	27.9
Мэдэхгүй	29	12.8
Сүүлийн нэг жилд хурал уулзалтанд оролцсон эсэх		
Тийм	85	37.6
Үгүй	141	62.4
Бүгд	226	100.0

Асуулга судалгааны дүнгээр ХАМО иргэдийн уул уурхайтай холбоотой асуудлаарх оролцооны эрхийн хэрэгжилт хангалтгүй байгаа дүр зураг ажиглагдаж байна. Тухайлбал, орон нутгийн удирдлагуудад иргэдийн зүгээс өгсөн өргөдөл гомдлын шийдвэрлэлт тааруу буюу маш муу гэж нийт судалгаанд оролцогчдын 71.3 хувь нь хариулсан байхад орон нутгийн удирдлага иргэдийн эрх ашгийг хөндсөн шийдвэр гаргахдаа иргэдийн оролцоог хангасан байдлыг дунд, тааруу, маш муу гэж 80.8 хувь нь үнэлсэн байна. Өөрөөр хэлбэл уул уурхайн асуудлаарх иргэдийн оролцооны эрхийн хэрэгжилтийг ХАМО иргэдийн дийлэнх нь муу хэмээн үнэлж байгааг харуулж байна..

Түүнчлэн судалгаанд хамрагдсан ХАМО иргэдийн дийлэнх нь буюу 62.4 хувь нь сүүлийн нэг жилд аливаа хурал уулзалтад оролцож мэдээлэл авч байгаагүй гэж хариулснаас үзвэл мэдээлэл авах эрхийн хэрэгжилт хангалтгүй байгааг илтгэж байна. ХАМО иргэдтэй

хийсэн бүлгийн ярилцлагаар ШХА-ийн ТБУТ-өөс зохион байгуулсан сургалтад хамрагдсан гэж хариулж байлаа.

ДӨРӨВ. УУЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БАЙГАЛЬ ОРЧИН БОЛОН БЭЛЧЭЭРИЙН МАЛ АЖ АХУЙД ҮЗҮҮЛЖ БУЙ НӨЛӨӨЛӨЛ

Уул уурхайн үйлдвэрлэлийн байгаль орчин, уламжлалт бэлчээрийн МАА-д үзүүлж буй нөлөөлөл, малчдын газар эзэмших, өмчлөх эрх, нүүлгэн шилжүүлэлт, нөхөн төлбөрийн зохицуулалт, байгаль орчны нөхөн сэргээлт, бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журмын хэрэгжилтийг судалсан судалгааны үр дүнг танилцуулж байна.

4.1 Уул уурхайн үйл ажиллагааны байгаль орчин ба бэлчээрийн мал аж ахуйд үзүүлж буй нөлөө

Уул уурхайн үйлдвэрлэл нь нүүдлийн МАА эрхэлдэг малчдын ахуй, нүүдлийн соёл иргэншилд сөрөг нөлөө үзүүлж байгааг энэ чиглэлээр хийгдсэн судалгаануудад дүгнэсэн байдаг. Судлаачид уул уурхайн компаниуд түрэн орж ирж орон нутгийн малчид шахагдаж буй өнөөгийн нөхцөлд нүүдлийн мал маллагааны соёлоо өв залгамжлуулах боломжгүй болсон өрхийн тоо өссөөр байгааг тэмдэглэж байна. Чанарын судалгаанд хамрагдсан орон нутгийн засаг захиргааны төлөөлөл, малчид, иргэд Уянга сумын Өлт, Заамарын сумын Хайлааст багийн нутаг нь булаг рашаан, гол устай, үржил шимтэй хөрс, өвс ургамалтай, модтой бэлчээрийн мал аж ахуй эрхэлдэг гол түшиц бүс нутаг байсныг тэмдэглэж байсан билээ.

- **Уянга сумын Өлт баг, Заамар сумын Хайлааст багийн нутагт уул уурхайн үйл ажиллагааны улмаас уламжлалт уламжлалт бэлчээрийн мал аж ахуйгаа эрхлэх аргагүй нөхцөл байдалд хүрч байна.**

Өлт багийн Засаг даргын үзсэнээр тус багийн нутаг дэвсгэр бүхэлдээ хайгуулын болон ашиглалтын лицензийн талбайд орсон, үүнээс шалтгаалж бэлчээрийн талбайн хэмжээ эрс багасч, малчид 4 улирлаар нүүх нутаг бэлчээр нь шахагдаж мал аж ахуйгаа эрхлэхэд хүндрэлтэй болжээ.

- Сумын ИТХ, багийн ИНХ-аас тухайн газрыг уул уурхайн зориулалтаар ашиглах эсэх асуудлаар саналыг нь авна гэсэн заалт Ашигт малтмалын тухай хуульд байдаг ч судалгаанд хамрагдсан Уянга сумын засаг захиргааны төлөөлөл тайлбарлахдаа орон нутаг эрх мэдэлгүй, дээрээс асуудлыг шийддэг тул хувийн компаниуд орон нутгийн удирдлагыг авч хэлэлцдэггүй, үл ойшоодог гэж байлаа. Тухайлбал орон нутгийн захиргаа хууль бус үйл ажиллагаа явуулж, малчдын өвөлжөө хаваржаанд халдаж байгаа, шинэ газрыг эвдэж сүйтгэж байгаа компаниудад торгууль тавих, лац тавих арга хэмжээг авдаг ч торгууль төлдөггүй, лацаа аваад дахин үйл ажиллагаагаа үргэлжлүүлж хууль биелүүлэхгүй байх явдал газар авчээ.

Заамар сумын орон нутгийн удирдлага лиценз олгохдоо багийн Иргэдийн Нийтийн хурлаас санал авч, ямар уурхай, хэдэн жилээр үйл ажиллагаа явуулах, нөхөн сэргээх төлөвлөгөө зэрэг асуудлаар нутгийн иргэдтэй зөвшилцөх үйл ажиллагааг хэрэгжүүлэхгүй байна.

Матриц 4.1 Уул уурхайн үйл ажиллагааны бэлчээрийн мал аж ахуйд үзүүлж буй сөрөг нөлөөлөл

	Уянгын уурхай	Заамарын уурхай
Нэг. Малчид		
Уул уурхайн улмаас бэлчээрийн 60 хувь сүйтгэгдсэн	+	+
Өлт голыг уул уурхайн компаниуд алтаа угаах цөөрөм болгож гол усгүй болгосон	+	
Уул уурхайн компаниуд Өлтийн хөндийд 70-80 хиймэл бохир нуур бий болгосон	+	
Өлтийн хөндийн гадарга, гүний усыг их хэмжээгээр соруулж алтаа угаадаг	+	
Өлтийн булаг, горхи ширгэсэн	+	
Уул уурхайн компаниуд Өлтийн хөндийд 200-аад худаг гаргасан	+	
АУМ компани ашиглалтын лицензээр олгогдсон газраасаа илүү хэмжээний газрыг эвдэж сүйтгэсэн	+	
Мянганбаяр 3-4 уулын оройг ухаж сэндийлж суваг татаад хаясан	+	
АМГ малчин айлын өвөлжөө хаваржааны газарт ашиглалтын лиценз давхцуулан олгодог	+	
Орон нутгийн захиргаа, дарга нар АУМ болон бусад компаниудаас мөнгө авч газраа зардаг	+	
4 улирлаар нүүх нутаггүй болсон	+	+
Хөдөөгийн малчдын нүүдлийн амьдралын хэв маяг алдагдаж байна	+	
Уурхай голоо дагаад байрлаж байгаа тул Туул гол маш их бохирдсон		+
Малчид малаа Туул гол руу бэлчээх нөхцөлгүй болсон \суваг шуудуу, канал ухсан\		+
Хоёр. ХАМО иргэд		
Газрыг уул уурхайн олон хувийн компаниудад өгснөөр байгаль орчин доройтож байна	+	+
Гурав. Орон нутгийн захиргааны төлөөлөл		
Нинжа нар уулын модыг замбараагүй огтолдог, түлшинд хэрэглэдэг	+	

Малчидтай хийсэн ярилцлагаар уул уурхайн үйл ажиллагааны нөлөөгөөр Өлтийн хөндийн бэлчээрийн газрын 60 хувь нь эвдэгдэж, уул уурхайн компаниуд Өлтийн голд алтаа угааж олон тооны хиймэл нуур гаргах, ашиглалтын лицензтэй компаниуд нь зөвшөөрснөөс илүү их хэмжээний бэлчээрийн газрыг эвдэж сүйтгэж байна.

4.2 Уул уурхайн үйл ажиллагааны нөлөөлөлд өртсөн орон нутгийн иргэдийн газар эзэмших, өмчлөх эрхийн хэрэгжилт


Малчдын эрт дээр үеэс эзэмшиж, ашиглаж ирсэн өвөлжөө хаваржаа, намаржааны бэлчээрийн газар болон малчдад өвөлжөө, хаваржааны зориулалтаар эзэмшүүлэхээр өгсөн гэрчилгээтэй талбайд ашиглалтын лиценз давхцуулан олгосноор уул уурхайн компаниуд айлын гэрийг тойруулан ухаж мал маллах аргагүй нөхцөл байдалд хүргэж байна. АМГ, уул уурхайн компаниуд лиценз нэрээр далайлган малчин өрхүүдийн үе

уламжлан эзэмшин ашиглаж ирсэн газар бэлчээрт халдаж байна. Малчдын хэлснээр өглөө, эсвэл шөнө гэрийг нь тойруулаад ухдаг тул хүн малгүй идээшиж дассан орон нутаг, өвөлжөө бууцаа орхин нүүхээс өөр аргагүй нөхцөл байдалд оруулж газар эзэмших, ашиглах эрхэнд нь шууд халдах явдал жирийн үзэгдэл болж байна.

Жишээ 4.1

Уул цурхай эндэхийн гол горхийг үгүй хийсэн. Их Бага Өлт гэж хоёр сайхан гол байсан одоо ширгэсэн. Малчид 15-20 километр явж байж ундны усандаа хүрдэг болсон.

(Бүлгийн ярилцлага, Заамар сумын Хайлааст багийн малчид)



Жишээ 4.2 Манайх таван үеэрээ өвөлждөг байсан.

Өвөрхангай аймгийн Уянга сумын Засаг даргын 2008.09.04 –ний өдрийн 104 тоот шийдвэрээр 700 км/ газрыг 15 жилийн хугацаатайгаар өвөлжөөний зориулалтаар эзэмших 0139377 дугаартай гэрчилгээ, 2010.03.09-ний өдрийн 38 тоот шийдвэрээр 1000 км/ 0.1 га баруун ширээгийн урд хоолой газрыг 15 жилийн хугацаатайгаар хаваржааны зориулалтаар эзэмших 01662222 бүхий гэрчилгээ тус тус авсан. Гэтэл манай хаваржаа, өвөлжөөний газартай давхцуулан Ашигт малтмалын газраас ашиглалтын лиценз олгосноор 2006

оноос Монгол Чехийн хамтарсан “ АУМ” компани олборлолт явуулж хаваржаа, өвөлжөөг тойруулан ухсан тул хэдэн малаа сумын төвд айлд тавьж одоо өөрсдөө амьдрахын эрхэнд алт ухдаг болсон. “АУМ” компани хаваржааны газрын нөхөн төлбөр 1 сая төгрөг нэг удаа л өгсөн. Өвөлжөөний газрын нөхөн төлбөр авъя гэхэд энэ манай худалдаад авчихсан газар гээд авч хэлэлцдэггүй. Гэтэл би сумын Засаг даргатай байгуулсан газар эзэмших гэрээгээр хаваржаа, өвөлжөөний газрын төлбөрт жил бүр 10000 төгрөг төлөөд байдаг.

(Ганцаарчилсан ярилцлага, Уянга сумын малчин)

Дээрх тохиолдолд малчин Д нь Газрын тухай хуулийн дагуу хаваржааны 0.7 га газрыг эзэмших гэрээг Уянга сумын Засаг даргатай байгуулсан бөгөөд Газрын тухай хуулийн 35.1.3-т газар эзэмшигч ньучирсан хохирлоо гэм буруутай этгээдээр тогтоосон журмын дагуу нөхөн төлүүлэх, 20.2.2-т Засаг дарга нь газар эзэмшигч, ашиглагчаас газар, түүний баялгийг хууль тогтоомж, гэрээний дагуу үр ашигтай, зохистой ашиглаж, хамгаалж байгаад хяналт тавих, зөрчлийг арилгах шийдвэр гаргаж, хэрэгжилтийг зохион байгуулах бүрэн эрхтэй байх зэрэг хэм хэмжээг хуульчилж өгсөн байна. Энэ зохицуулалтаар сумын Засаг дарга малчдын өвөлжөө хаваржааны газрыг хууль бусаар уурхайн эдэлбэр газрын зориулалтаар авсан тохиолдолд хяналт тавих, зөрчлийг арилгуулах малчдад учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх заалтын хүрээнд малчдын эрх ашгийг хангаж хамгаалах боломж байдаг ч энэхүү эрхээ огт хэрэгжүүлж ирээгүй байна. Эсрэгээр уг хаваржааны 0.7 га газрыг эзэмшин ашиглах хуулиар олгогдсон эрхтэй малчин гэрийн буурины хэмжээтэй 100 метр газартай хоцорч, 2006 оноос хойш Үндсэн хуулиар олгогдсон газар эзэмших эрхээ эдэлж чадахгүй өдийг хүрчээ. Эндээс харахад уул уурхайн компаниуд хуулиас давсан хууль бус нийтийн эрх ашигт харшилсан үйлдлүүдийг байнга хийж ирсэн бөгөөд хуулийг хэрэгжүүлэх чиг үүрэг хүлээсэн орон нутгийн удирдлагууд нь энэхүү хууль бус үйлдлийг хаацайлж чимээгүй өнгөрөөдөг,

тэдэнтэй ашиг сонирхол нь нэгдсэн байх магадлал өндөр байгаа нь судалгаанд оролцогчдын өгсөн мэдээллээс тодорхой харагдаж байна.

Жишээ 4.3

Малчид малаа Туул гол руу бэлчээх ямар ч боломжгүй болсон. Том том уурхайнууд канал татаад орох замыг нь хаасан. Шав тэмдэг тавьж энэ манай талбай гэдгийг нь мэдэгдэх ёстой болохоос канал, суваг татна гэсэн зүйл ерөөсөө байх ёсгүй. Ийм байдлаар малчдын бэлчээрээ эзэмших эрх ашиг нь шууд зөрчигддөг.

(Ганцаарчилсан ярилцлага, Заамар сум)

Дотоодын хууль тогтоомжтой нэгэн адил хүчин чадалтай, Монголын Улсын нэгдсэн орсон Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактад “Аливаа ард түмнийг ямар ч тохиолдолд оршин тогтнох хэрэглүүрээс нь салгаж үл болно.” гэсэн заалт Уянга, Заамарын суманд зөрчигдөж байна. Судалгаанд оролцогчид хэдэн үеэрээ амьдарч ирсэн нутгийн уугуул иргэд, малчдын эрх, эрх чөлөө нь ашигт малтмал ашиглах үйл ажиллагаатай холбогдон хэрхэн зөрчигдөж буйг олон жишээ баримтад тулгуурлан хэлж байлаа.

Малчдын өгсөн мэдээллээр Өлтийн хөндий нь Өлт багийн малыг шингээж байсан бол уул уурхайн үйл ажиллагааны нөлөөгөөр нутаг бэлчээр нь шахагдаж, малчид малаа бэлчээх газаргүй болоход хүрчээ..

***Жишээ 4.4** Нэг шөнө унтаад сэрэхэд гэрийн буурийг тойруулаад ухсан байдаг. Өвөлжөө хаваржааны 100 метр газар үлдээгээд бусдыг нь ухаад байгаа. Одоо Өлт уруудаад замбараагүй олон зам бий болсон, хүнд даацын машин ч их явж бэлчээр, газрыг сүйдэлж байна. Хэдхэн хүн уурхайгаар баяжиж байна.*

Дээрх судалгааны баримт, малчдын өгсөн мэдээллээс харахад уул уурхайн компаниуд газар нийтийн өмч байгааг далимдуулан нутгийн иргэд, малчдыг хохироож байна. Түүнчлэн малчид, иргэд газар эзэмшиж талаар хуулийн мэдлэг хомс байгаа нь уул уурхайн компаниудад өвөлжөө хаваржаа, намаржааны газраа алдахад тодорхой хэмжээгээр нөлөөлж байна. Газрын тухай хуулиар баталгаажсан малчид өвөлжөө, хаваржааны газар эзэмших эрхийг уул уурхайн компаниуд зөрчиж байгаагийнхаа төлөө огт хариуцлага хүлээдэггүй байна. Төр засаг, орон нутгийн захиргааны байгууллага нь ч эрх нь зөрчигдсэн иргэдийнхээ эрхийг нөхөн сэргээх, хөндөгдсөн эрхийг хангаж хамгаалсан тохиолдол байхгүй байна.

Судалгаанд хамрагдсан малчдын үзэж байгаагаар нутаг, бэлчээрийн 60-70 хувь нь уул уурхайн үйл ажиллагааны улмаас талхлагдаж сүйтгэгдсэн, алтны компаниуд гол усны гольдролыг өөрчлөн карьер хийж алтаа угааж ус бохирдуулсан, гол горхи ширгэсэн, байгалийн унаган төрх алдагдаж, бэлчээр газрыг нь хүчээр булааж малчид малаа маллаж амьдрах аргагүй нөхцөл байдалд хүрч байна.

Жишээ 4.5

Өнгөрсөн жил Ашигт малтмалын газраас шалгалтууд ирсэн. Дараа нь үр дүн огт гардаггүй. Өөрийн талбайгаасаа илүү газарт хулгайгаар олборлолт явуулж байна гэсэн гомдлыг малчид, иргэд тавьсан. Уурхайг хаасан. Хаасныхаа маргааш нь нээчихсэн байсан. Нээх акт гаргачихсан байсан. Одоо “Тод Ундарга” ХХК-д нутгийн шүтээн уул Баясгалантыг лицензтэй талбайд нь олгочихсон байна. Нутгийн иргэдээс асуугаагүй. Одоо ухаад талд нь орчихоод байж байна. Манай нутаг ам болгондоо устай байсан. Газар тариалан эрхлээд манай сум 1986 онд улсад тэргүүлж байсан. Одоо уул уурхай нь газар тариалангаа дарж хаялаа. Ингээд манай сумын үндсэн хөгжих чиглэл нь юу вэ гэдэг нь тодорхойгүй болчихсон. Энд байгаа хэдэн малчид

уулын аманд шахагдаад уулын тагтан дээр л амьдарч байна. Усны бохирдол маш ихтэй. Уурхай гол дагаж байрлаж байгаа учраас мал оруулах хэцүү.

(Ганцаарчилсан ярилцлага, Заамар сумын Хайлааст багийн засаг дарга)

Судалгаанд оролцсон иргэдийн үзэж байгаагаар эцэг өвгөдөөсөө үе уламжлан өвлөж авсан малчдын өвөлжөө, хаваржаа, намаржааг нэг л өдөр уул уурхайн компани манай лицензтэй талбай гэж хэлэн ухдаг, малчид уул уурхайн компаниудад шахагдан нүүсээр одоо нүүх газаргүй болж байна. Уул уурхайн үйлдвэрлэл нь 4 улирлаар нүүдэллэдэг уламжлалт бэлчээрийн мал аж ахуй, нүүдлийн соёл иргэншлийг үе уламжлан хадгалж дараа үедээ дамжуулдаг малчдын амьдралын хэв маяг, амьжиргаанд нь сөрөг үр дагавартай байна гэж дүгнэж болохоор байна.

4.3 Нүүлгэн шилжүүлэлт, нөхөн төлбөрийн зохицуулалт

Уул уурхайн салбарын байгаль орчин ба уламжлалт бэлчээрийн МАА-д сөрөг нөлөөллийг бууруулах, бууруулах арга хэмжээнд газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлт, нөхөн олговрын асуудал хөндөгддөг. Нийгмийн өмнө хариуцлага хүлээдэг нийгмийн хариуцлагатай уул уурхайн компаниуд тухайн орон нутгийн байгаль орчин ба нийгэмд үзүүлэх бүхий л нөлөөллийг үнэлж, үнэлгээнд суурилсан сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг нөлөөлөлд өртөж буй орон нутгийн захиргааны байгууллага, нутгийн иргэдтэй зөвшилцөж тэдний саналыг тусгаж шийддэг.

Ашигт малтмалын тухай хуулийн 41 дүгээр зүйлд “Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хайгуулын болон ашиглалтын үйл ажиллагааны явцад худаг, өвөлжөө, хувийн болон нийтийн зориулалттай орон байр бусад барилга байгууламж болон түүх, соёлын дурсгалт зүйлсэд гэм хор учруулсан бол хохирлыг нь өмчлөгч, эзэмшигчид бүрэн хэмжээгээр нөхөн төлөх бөгөөд шаардлагатай тохиолдолд тэдгээрийг шилжүүлэн байрлуулахтай холбогдсон зардлыг хариуцна.” гэж заасан. Уянга сумын Өлт багийн малчид уул уурхайн үйл ажиллагааны нөлөөлөлд өртснөөс цөөн тооны малчид уул уурхайн компанитай харилцан тохиролцож өвөлжөө, хаваржааны газраа алдсаны нөхөн төлбөр авч байгаа нь судалгаагаар харагдаж байлаа.

Судалгаанд хамрагдсан 2 сумын жишээн дээр авч үзэхэд уул уурхайн үйл ажиллагааны сөрөг нөлөөллийн улмаас өвөлжөө, хаваржаа, намаржааны бэлчээргүй болсон, мал маллах аргагүйд хүрсэн улмаар Үндсэн хуулиар олгогдсон газар эзэмших эрхээ эдэлж чадахгүйд хүрсэн олон жишээ баримтуудыг судалгаанд оролцогчид хэлж байгаа ч уул уурхайн нөлөөлөлд өртөж хохирсон малчдад газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтийн арга хэмжээг авсан нэг ч уул уурхайн компани байсангүй.

Жишээ 4. 6	
Уянга сум	Заамар сум
Анх би нөхөн төлбөрийн талаар юу ч мэддэггүй байлаа. Сүүлийн үед гарын авлага, хууль тогтоомж уншиж танилцаад ийм зүйл байдгийг мэдээд өвөлжөөний газраасаа нөхөн төлбөр авдаг болсон. Уул уурхайн компанитай нөхөн төлбөрийн асуудлаар гэрээ байгуулаад 2 жил болж байгаа ба жилд 4 өвөлжөөний 250-500 мянган төгрөгийн нөхөн төлбөр авдаг. Өвөлжөөний эзэн надад 500,000, манайтай айл амьдардаг хүргэнийд 250 мянган төгрөгийн нөхөн төлбөр өгдөг.	Малчин Мягмардорж гуай Монполимет ХХК-аас өвөлжөөний газраа орхиж нүүсний нөхөн төлбөр авсан. Нутгийн иргэд энд хэдэн үеэрээ амьдраад ирсэн байхад одоо нөхөн төлбөр өгөх нь битгий хэл та нар уурхайн талбайгаас яв гэдэг болсон. Мал хүртэл идээшиж дассан нутгаасаа явахгүй, эргэж очоод байна. <i>(Ганцаарчилсан ярилцлага, Заамар сум, Хайлааст багийн Засаг дарга)</i>

(Уянга сум, Ганцаарчилсан ярилцлага, Малчин өрх)	
--------------------------------------------------	--

Ихэнх малчдын хувьд уул уурхайн үйл ажиллагааны нөлөөгөөр малчид чөлөөтэй нүүдэллэхэд боломжгүйд хүрч амьжиргаанаасаа салж, МАА-аас олох орлого нь хомсдсон байна. Малчид уул уурхайн компаниудад бэлчээрээ алдаж өвөлжөө хаваржаагаа орхин нүүх арга замыг сонгож байгаа нь орон нутгийн удирдлага, малчид, иргэдтэй хийсэн ярилцлагаас харагдаж байна.

Матриц 4.2 Лицензийн талбайд орсон болон нөхөн төлбөр авч буй малчдын тоо

	Уянга сум	Заамар сум
Уул уурхайн эдэлбэр газар, лицензийн талбайд орсон малчдын өвөлжөө хаваржааны тоо	10 гаруй	12
Үүнээс нөхөн төлбөр авч буй малчдын тоо	4*	1

Тайлбар*: Иргэдийн өгсөн мэдээлэл

Заамар сумын малчдын жишээн дээр авч үзэхэд нийт 12 малчны өвөлжөө хаваржаа уурхайн лицензийн талбайд орж эвдэгдсэн байдаг ч зөвхөн нэг малчин жилд нэг удаа нөхөн төлбөр авч байна. Харин Уянга сумын судалгаанд хамрагдсан малчдын хэлснээр нийт 4 малчин уул уурхайн компанитай 4 жилийн турш нөхөн төлбөр авах гэрээ хийж, жилд нэг удаа 250.000-500.000 төгрөгийн нөхөн төлбөр авч байна.

Жишээ 4.7

Багийн ИНХ-аар хэлэлцээд Засаг даргын захирамжаар өвөлжөө, хаваржааны доорхи газрыг олгодог. Мод мухар гэдэг уурхайд гурвалсан гэрээ байгуулаад нөхөн төлбөр авч байгаа айлууд бий. Зарим айлууд тухайн компанитайгаа тохиролцоод суманд мэдэгдэлгүй жил бүр төлбөр авдаг.

(Уянга сум, Ганцаарчилсан ярилцлага, Газрын даамал)

Ерөнхийдөө уул уурхайн компаниуд 2-3 жилээр буюу тухайн орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа үедээ малчдад нөхөн төлбөр төлж байгаа нь ажиглагдаж байна. 2 жилийн гэрээ дуусч, уул уурхайн компаниуд явсны дараа өвөлжөө хаваржааны бэлчээрээ сүйтгүүлсэн малчин яах вэ гэдэг асуудал тодорхойгүй хэвээр үлдэж байгаа төдийгүй бэлчээр, байгалийн нөөцөөс шууд хамааралтай нүүдлийн мал аж ахуй эрхэлдэг малчин өрхийн эдийн засгийн алдагдлыг тооцох асуудал орхигдож байна.

Нөгөө талаар ихэнх малчдын хувьд өвөлжөө хаваржааны газрын эзэмшил, нөхөн төлбөр, уул уурхайн компаниудын нийгмийн хариуцлага гэх мэт малчин хүний эрх ашиг, эрх, эрх чөлөөнд хамааралтай асуудлын талаар хангалттай мэдээлэлгүй байгаа явдал нь малчны газар эзэмших, ашиглах, өмчлөх, өвөлжөө бууцаа хамгаалах, оршин суух эрхэнд нь халдах боломжийг нийгмийн хариуцлагагүй, хууль дээдэлдэггүй уул уурхайн компаниудад олгож байна.

- **Сумын орон нутгийн захиргааны байгууллагад уул уурхайн нөлөөлөлд өртсөн малчдыг нүүлгэн шилжүүлэх, газар чөлөөлөлт, малчдын өвөлжөө хаваржааны эзэмшил түүний нөхөн төлбөрийн асуудлыг зохицуулах тал дээр авч хэрэгжүүлж байгаа бодлого, арга хэмжээ огт байхгүй байна.**

Зөвхөн уул уурхайн компани, малчдын хоорондын асуудал гэсэн хандлагаар хандаж байгаа нь нийтлэг ажиглагдлаа. Уул уурхайн үйл ажиллагааны сөрөг нөлөөллийн улмаас

газар эзэмших, өвөлжөө хаваржааны газар эзэмших, амьдралын хүрэлцээтэй түвшинд аж төрөх эрхээ хэрэгжүүлж чадахгүй байгаа нутгийн иргэд, малчдын өмнөх амьдралыг хэв маяг, амьжиргааг нь алдагдуулахгүйгээр газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлт, нөхөн олговрын арга хэмжээг Монгол улсын хууль тогтоомж, олон стандартуудын хүрээнд авч хэрэгжүүлэхэд чухал нөлөөтэй оролцогч тал бол яах аргагүй орон нутгийн захиргааны байгууллага. Гэтэл өнөөдөр иргэдийнхээ эрх ашгийг хамгаалах, төлөөлөх үүрэгтэй орон нутгийн удирлагууд нь энэ талаар ямар ч арга хэмжээ авч хэрэгжүүлэлгүй едий хүрчээ.

4.4 Уул уурхайн компаниудын байгалийн нөхөн сэргээлтийн үйл ажиллагаа

Малчид уул уурхайн үйл ажиллагааны улмаас тухайн бүс нутгийн экосистем тухайлбал ус, бэлчээр, хөрс, агаар бохирдсон гэж үзэж байна. Үүнд:

- Уянга сумын Өлтийн голын доош урсаж байгаа ус уухын аргагүйгээр бохирдсон
- Заамар сумын Хайлааст багийн нутаг дэвсгэрт байгаа Туул голын усыг хүн мал хэрэглэхийн аргагүй бохирдсон
- Үер болоогүй байхад байнга булингартай байдаг
- Нинжа нар болон гадны иргэд нойтон модыг их хэмжээгээр огтолдог
- Өлтийн хөндий хог шороондоо дарагдсан
- Ан амьтан, тарвага зурам байхгүй болсон
- Дарга нар бүгд хүний нэр дээр уурхайтай, энэ нь уул уурхайн компаниудад шаардлага тавих, хууль бус үйлдэлтэй тэмцэхэд саад болдог
- Ард түмэнд уул уурхай, байгаль орчин, газартай холбоотой бодит мэдээлэл байхгүй
- Уул уурхайн улмаас байгаль орчинд учирч байгаа хор хохирлын талаарх хяналт үнэлгээ, судалгаа байхгүй.

Малчид уул уурхайн компаниуд хуулиар хүлээсэн үүрэг, нутгийн иргэдэд амалсан амлалтуудаа биелүүлдэггүй дээр нь орон нутгийн засаг захиргаа энэ талаар юу ч хийдэггүй хэмээн шүүмжилж байв.

Асуулга судалгаанд оролцогчдоос тухайн уул уурхайн компаниуд орон нутгийн байгаль орчинд нөхөн сэргээлт хийдэг эсэхийг тодруулахад нийт судалгаанд хамрагдсан ХАМО иргэдийн 53.1 хувь нь огт хийдэггүй, 40.7 хувь нь нөхөн сэргээлт хийдэг ч туйлын хангалтгүй гэж хариулав. Нийт судалгаанд оролцогчдын бараг 90 гаруй хувь нь уул уурхайн нөхөн сэргээлтийг стандартын дагуу хийж чаддаггүй хэмээн үзлээ.

Хүснэгт 4.1 Уянга, Заамар сумдад уурхайн нөхөн сэргээлт хийдэг эсэх

	Уянга сум	Заамар сум	Бүгд
Тийм	4.6	7.7	6.2
Хийдэг боловч үр дүн хангалтгүй	35.8	45.3	53.1
Үгүй	59.6	47.0	40.7
Бүгд	100.0	100.0	100.0
Тоо	109	117	226

Уул уурхайн үйл ажиллагаа нь байгаль орчинд, байгаль орчноор дамжин хүнд сөрөг нөлөө үзүүлж байна. Тоон судалгааны дүнгээс харахад Уянга, Заамар сумд дахь алт олборлох үйл явцын улмаас газар, бэлчээр, хөрс, ус зэрэг байгалийн нөөцөд учруулж буй хохирлыг нөхөн сэргээх үйл ажиллагаа туйлын хангалтгүй явагдаж байгаа нь харагдаж байна. Судалгааны мэдээлэл цуглуулах явцад орон нутгийн захиргаа техникийн нөхөн сэргээлт хийсэн гэж ярьж байгаа ч стандартын дагуу хийдэггүй, хийсэн нэр зүүдэг хэмээн малчид үзэж байлаа.



Зураг 4.1 Заамарын уурхай



Зураг 4.2 Уянга сумын Өлтийн уурхай

Уул уурхайн компаниуд тухайн орон нутгийн экосистем, байгаль орчныг унаган төрхөнд нь буцааж оруулна гэсэн гэрээ хийдэг ч үнэн хэрэгтээ ухсан нүх, овоолсон шороо, хог хаягдал, бохирдсон ус, талхалсан хөрс, бэлчээрийг нутгийн ард иргэдэд үлдээж байна.

Нутгийн иргэд, малчид нөхөн сэргээлт хийх нэрийдлээр ашиглаад орхисон талбай дээр уул уурхайн компаниуд алт олборлодгийг шүүмжилж байлаа.

Уянга сумын Өлтийн уурхайн хувьд лиценз нь “Эрэл” компаниас эхлээд “АУМ” ХХК-ны эзэмшилд гэх мэтээр олон компанийг дамждаг нь нөхөн сэргээлтийг хэн хариуцаж хийх асуудлыг ихээхэн бүрхэгдүүлдэг байна. Ийм нөхцөл байдлаас болж эцсийн дүндээ нутгийн иргэд, малчид хамгийн их хохирч үлддэг байна.

- Судалгаанд хамрагдсан малчид нутаг орон, бэлчээр бууцаа өөрийн нүдээр сүйтгэхийг нь үзлээ, буцаагаад нөхөн сэргээж унаган төрхөнд нь оруулахыг нь хармаар байна гэсэн билээ. Харин нөхөн сэргээлтийг хэн гэдэг эзэнтэй, ямар компани хийх вэ гэдэг асуудал өнөө хэр нь тодорхойгүй үлдэж байна.

Малчдын хэлж байгаагаар алтны компаниуд хамгийн сайхан ус, бэлчээртэй газрыг нь ухаж сүйтгэж байгаад хамгийн ихээр санаа нь зовж байна. Нутгийн малчид нөхөн сэргээлт хийсэн ч байгаль орчин унаган төрхөндөө орно, өвс ургамал, булаг шанд сэргэнэ гэдэгт огт найдахгүй байгаа нь судалгааны дүнгээр харагдаж байна. Малчид уул уурхайн компаниуд нутаг орон, мал аж ахуй, амьдрах орчинд нь нөлөөлөх сайн сайхан зүйл олж харахгүй байгаагаа хэлж харин ч нутаг ус, гол усаа сүйтгэгдэж байгааг харж, амьжиргаанаасаа салахад хүрч байна гэлээ.

Уул уурхайн компани үйл ажиллагаа явуулж байгаа орон нутагтаа уурхай, газар ашиглалттай холбоотой төлбөрөө төлж байгаа эсэх, хэдэн хувь нь орон нутагт үлдэж байгаа, үүнээс байгаль орчныг нөхөн сэргээхэд зарцуулагдаж байгаа эсэх, нөхөн сэргээх үйл ажиллагаа явуулахад орон нутгийн захиргаа, иргэдийн оролцоог хангадаг эсэх асуудал бүрхэг байна.

ДҮГНЭЛТ

Швейцарийн Хөгжлийн Агентлагийн Тогтвортой бичил уурхай төсөл, Хүний Эрхийн Үндэсний Комиссийн судалгааны баг “Монгол Улс дахь Бичил уурхай ба Хүний эрх” судалгааг хамтран хийж гүйцэтгэлээ. Энэхүү судалгааны хүрээнд Өвөрхангай аймгийн Уянга, Төв аймгийн Заамар сумын бичил уурхай дахь хүний эрхийн төлөв байдалд нөхцөл байдлын үнэлгээ, судалгааг хийж, судалгааны үр дүнд тулгуурлан дүгнэлт зөвлөмж боловсруулав.

Судалгаанд Уянга, Заамар сумдад бичил уурхайгаар ашигт малтмал олборлож байгаа ХАМО иргэн 261, уул уурхайн үйл ажиллагааны нөлөөлөлд өртсөн малчин 24, орон нутгийн удирдлага, мэргэжилтэн 17, уул уурхайн харуул хамгаалалтын албаны ажилтан 4. нийт 306 хүнийг хамруулахдаа нийгмийн судалгааны тоон болон чанарын судалгааны аргуудыг хослуулан хэрэглэж судалгааны зорилго, зорилтуудыг хэмжихүйц мэдээллийг цуглуулж, дүн шинжилгээ хийлээ.

Судалгааны үр дүнд тулгуурлан дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

Нэг. Бичил уурхай эрхлэгч иргэдийн түр буюу байнга оршин суух газраа сонгох эрхийн хэрэгжилт

- Судалгааны үр дүнгээс харахад бичил уурхайн үйл ажиллагаа эрхэлж байгаа ХАМО иргэдийн дийлэнх нь одоогийн оршин сууж байгаа орон нутгийн засаг захиргаанд оршин суугчаар бүртгүүлээгүй байгаа нь Үндсэн хуулиар баталгаажсан иргэдийн оршин суух газраа сонгох эрхээ эдэлж чадахгүй байгааг харуулж байна. Ялангуяа Уянга суманд бусад аймаг, сумдаас ирж бичил уурхай эрхэлж байгаа иргэдийн дийлэнх нь буюу 97 хувь нь бүртгэлгүй байгааг судалгааны дүн илтгэж байна.
- Иргэдийн Үндсэн хууль, хууль, олон улсын гэрээгээр баталгаажсан эрх, эрх чөлөө зөрчигдөхөд орон нутгийн удирдлага, төрийн албан хаагчдийн хувийн үзэл, хандлага голлон нөлөөлж байгаа нь сум орон нутгийн холбогдох албан тушаалтнууд иргэдийн шилжилт хөдөлгөөнийг үндэслэлгүйгээр бүртгэхээс татгалздаг, буцаж нүүхийг шаарддаг нь судалгаанд оролцогчдын хариулснаас харагдаж байна. Заамар сумын иргэний бүртгэлийн байгууллага орон нутаг ачааллаа даахгүй байна гэдэг шалтгаанаар ХАМО иргэдийг оршин суугчаар бүртгэхгүй байх бодлого баримтлаж буй нь Монгол Улсын иргэн улсынхаа нутаг дэвсгэрт чөлөөтэй зорчих, түр буюу байнга оршин суух газраа сонгох Үндсэн хуулиар олгогдсон эрхээ эдлэхэд нь зарим талаар саад болж буй хүчин зүйл болж байна. Нөгөө талаас ХАМО иргэд тухайн шилжин ирсэн газартаа иргэний бүртгэл хийлгэх үүргээ биелүүлэхгүй байх явдал ч байна. Нийт судалгаанд хамрагдсан ХАМО иргэдийн 70 гаруй хувь нь бүртгэлийн албанд хандаагүй, эсхүл харъяалах сум орон нутагтаа бүртгэлтэй гэсэн хариулт өгсөн болно.
- Бичил уурхайн үйл ажиллагаа эрхэлж буй иргэд тухайн орон нутагтаа оршин суугчаар бүртгүүлээгүйн улмаас нийгмийн халамжийн болон эрүүл мэндийн тусламж үйлчилгээ цаг тухайд нь авч чадахгүйд хүрч байгааг ХАМО иргэд, орон нутгийн удирдлагууд, эмч, эмнэлгийн ажилтнууд хүлээн зөвшөөрч байлаа.

Хоёр. Бичил уурхай эрхлэгч иргэдийн амьдралын хүрэлцээтэй түвшинд аж төрөх эрхийн хэрэгжилт

- Уянга, Заамар сумдад бичил уурхайн үйл ажиллагаа эрхэлж байгаа иргэд дээд тал нь 8-аас дээш жил, доод тал нь 2 жил бичил уурхайгаар ашигт малтмал олборлож

байгаа бөгөөд эдгээр сумдын хүн амын 70 гаруй хувь нь хувиараа алт олборлож амьжиргаагаа залгуулж байна. Үүний нэг жишээ нь Уянга, Заамар сумын бичил уурхай эрхлэгчдийн 36.3 хувь нь төрийн байгууллага, хувийн байгууллагад ажилладаг, ажилгүй, улирлын чанартай ажил эрхэлдэг иргэд эзэлж байгаас харагдаж байна. ХАМО иргэдийн үзэж байгаагаар орон нутагт ажлын байр байхгүй, нас хүйсээр ялгаварлаж ажилд авдаггүй, амьдралын бололцоогүй, зуданд малаа барсан, оюутан хүүхдийн сургалтын төлбөрийг төлөхийн тулд бичил уурхайн үйл ажиллагаа эрхэлж байна.

- Орон нутгийн удирдлагуудын өгсөн мэдээллээр Уянга суманд 200 гаруй, Заамар суманд 600 гаруй иргэд хувиараа ашигт малтмал олборлож байгаагаас ашигт малтмал олборлох эрх авсан бичил уурхайн нэг нөхөрлөл байгаа нь Засгийн газраас баталсан “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам” тухайн орон нутгуудад бүрэн хэрэгжиж чадахгүй байгааг харуулж байна. Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох эрх зүйн орчин бүрдсэн ч Заамар суманд зөвхөн 50 гаруй иргэн нөхөрлөлийн хэлбэрээр зохион байгуулалтад орж уул уурхайн компанийн талбайд гэрээгээр олборлолт явуулж байгаа бол дийлэнх хэсэг нь уул уурхайн компаниудын талбайд зөвшөөрөлгүйгээр олборлолт явуулж байна.
- Бичил уурхай эрхлэгч иргэдийн дийлэнх нь тухайн орон нутагтаа бүртгэлгүйн улмаас нөхөрлөлийн зохион байгуулалтад орох боломжгүй байна. Хэдийгээр бичил уурхай эрхлэх эрх зүйн таатай орчин бүрдүүлж эхэлснээр бичил уурхайчид нөхөрлөлийн зохион байгуулалтаар бичил уурхай эрхлэх бололцоотой болсон ч судалгаанд хамрагдсан бичил уурхай эрхлэгчдийн дийлэнх нь тухайн орон нутагт оршин суугчаар бүртгүүлж чадаагүй байгаа явдал нь нөхөрлөл үүсгэн байгуулах, гишүүнээр элсэх цаашлаад газар эзэмших, ашиглах, өмчлөх эрхээ эдэлж чадахгүй байх нөхцөл байдалд хүргэж байна.
- ХАМО иргэд амьдралын хүрэлцээтэй түвшинд аж төрөх эрхээ эдлэх нь төр, орон нутгийн удирдлага, асуудал хариуцсан мэргэжилтнүүдийн хамтын ажиллагаа, хууль биелүүлэх байдал, ХАМО иргэдэд хандах хандлагаас ихээхэн шалтгаалж байгааг судалгааны дүн харуулж байна. Ашигт малтмалын тухай хууль, Газрын тухай хууль болон “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам”-аар бичил уурхайн үйл ажиллагааг зохицуулж, ХАМО иргэд нөхөрлөлийн зохион байгуулалтад орж бичил уурхай эрхэлж болохыг баталгаажуулсан ч ХАМО иргэд тухайн орон нутагт бүртгүүлэх тухай заалтаар шалтаглан нөхөрлөлийн зохион байгуулалтад ороход нь зарим талаар хүндрэл учруулж байгаа нь ХАМО иргэдийн хөдөлмөрлөх эрхээ эдлэх боломжийг хязгаарлаж орон нутгийн захиргаа, уул уурхайн компани, ХАМО иргэдийн хооронд үл ойлголцл, зөрчлийг даамжруулж байна.
- Түүнчлэн нөхөрлөлийн гишүүд буюу бичил уурхайчдын олборлолт явуулах газрын асуудлыг хэлэлцэх, холбогдох байгууллагад тавьж шийдвэрлүүлэх эрх нь Засаг дарга болон ИТХ-д олгогдсон явдал, БОАЖЯ болон холбогдох төрийн байгууллагуудаас техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх эрхийг хувь хүн, ААНБ-уудад олгосон нь орон нутагт эрх мэдэлтнүүд танил тал, ах дүү, найз нөхдөдөө бичил уурхай нэрийн дор хууль бус үйл ажиллагаа эрхлэх боломж олгож байгааг үгүйсгэхгүй юм.
- Орон нутгийн удирдлага, цагдаагийн байгууллага нь уул уурхайн компанийн эрх ашигт үйлчилдэг, ХАМО иргэдийг шахан хавчиж, гадуурхах нөхцөл байдал нийтлэг байгааг тэмдэглэж байлаа. ХАМО иргэд, малчид сум орон нутгийн дарга нар ах дүү, найз нөхдийнхөө нэр дээр хувьдаа уурхайтай болсон хэмээн үзлээ.
- Судалгаанд хамрагдсан Уянга, Заамар сумдад бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журмыг хэрэгжилт удаашралтай төдийгүй хувиараа ашигт малтмал олборлогчдыг нөхөрлөлийн зохион байгуулалтад бүрэн шилжүүлэх үүрэг хүлээсэн

орон нутгийн удирдлагууд уг журмыг хэрэгжүүлэх хүчин чармайлт, сонирхол бага байгаа нь судалгаагаар ажиглагдаж байлаа.

- Нөхөрлөлийн хэлбэрээр бичил уурхайчдыг зохион байгуулалтад оруулж байгаа нь хувиараа ашигт малтмал олборлогчдыг албан ёсны статустай болгох сайн талтай ч энэхүү журмын заалт бодит амьдрал дээр хэрэгжих үндэслэл муутай байгааг судалгааны дүн харуулж байна. Тэрчлэн журмын хэрэгжилтэд орон нутгийн удирдлагууд, тухайлбал Засаг дарга, ИТХ-ын тэргүүлэгчдийн дарга нарын ашиг сонирхол, ХАМО иргэдэд хандах хандлагаас шалтгаалсан саад бэрхшээл сөргөөр нөлөөлж байгаа нь иргэд, ХАМО иргэдийн өгсөн мэдээллээс ажиглагдаж байлаа.
- Судалгааны явцад анхаарал татсан зүйл бол Уянга суманд насанд хүрээгүй хүүхэд бичил уурхайн үйл ажиллагаа эрхэлж сурч боловсрох, хөгжих, цаашлаад эрүүл аюулгүй орчинд аж төрөх, эрүүл мэндээ хамгаалуулах эрх нь зөрчигдөж байна. Хүүхдүүд эцэг эхдээ, өрхийн амьжиргаандаа тус нэмэр болох зорилгоор ийм сонголтыг хийж байгаа нь эмзэг асуудал болж байна. Хүүхдийн эрхийг хангаж, хамгаалахад гол үүрэгтэй институциуд болох сургууль, боловсрол, орон нутгийн захиргааны байгууллагууд харьяалалгүй, бүртгэлгүй бичил уурхай эрхлэгч өрхийн сургууль завсардсан хүүхдүүдийн сурч боловсрох эрхийг хангах арга хэмжээг огт хэрэгжүүлэхгүй байгааг илтгэж байна
- Нутаг дэвсгэрийн харьяаллаар авч үзвэл Заамар суманд бичил уурхай эрхэлж байгаа иргэдийн сарын дундаж орлого Уянга суманд ХАМО иргэдийнхээс харьцангуй өндөр байна. ХАМО иргэд цаашид ч бичил уурхайг орлогын гол эх үүсвэр нь хэвээр байна гэж үзлээ.

Гурав. Бичил уурхай эрхлэгчдийн газар эзэмших, өмчлөх эрхийн хэрэгжилт

- Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журмаар нөхөрлөлийн зохион байгуулалтад орж чадаагүй бичил уурхайчид алтны компаниудын ашиглалтын талбайд шөнийн цагаар, нууцаар орж ажиллах, эсвэл мөнгө өгч нүх ухах, шороо угаахаас өөр аргагүй нөхцөлд байдалд орж байгааг судалгааны дүн харуулж байна.
- Бичил уурхай эрхлэгчид, уул уурхайн компаниудын харуул хамгаалалтын ажилтнуудын хооронд олборлох газраас үүдэлтэй хэрүүл маргаан, зодоон, дарамт хүчирхийлэл байнга гардаг төдийгүй хохирогч нь бичил уурхай эрхлэгчид болж байна. Судалгааны явцад алтны компанийн эзэмшлийн талбайд орсон бичил уурхай эрхлэгчдийн амьд явах эрхэд нь халдаж амь насыг нь хохироосон жишээ баримтыг бичил уурхай эрхлэгчид дурдаж байлаа.
- ХАМО иргэд өөрийн сонгосон газраа оршин суух, нөхөрлөлийн гишүүнээр элсэх, олборлолт явуулах эрхээ хэрэгжүүлж чадахгүй байгаагаас болж нэр төртэйгээр амьдрах, хөдөлмөрлөх, газар эзэмших, өмчлөх, эрүүл мэндээ хамгаалуулах, нийгмийн халамж хүртэх, хүрэлцэхүйц амьжиргааны түвшинтэй байх, цаашилбал амьд явах эрхүүд нь давхар хөндөгдөж байна.
- ХАМО иргэдээс өөрийн эзэмших, өмчлөх газартай эсэхийг тодруулахад нийт судалгаанд оролцогчдын 73.9 хувь нь байхгүй хариулсан бөгөөд 20 гаруй хувь нь өөрийн газартай гэж хариулахдаа өвөлжөө, хаваржааны болон гэр бүлийн зориулалтаар эзэмшиж буй газраа тооцон хариулж байлаа.
- Өнөөдрийг хүртэл бичил уурхай эрхлэгчид эзэмших, ашиглах, олборлолт явуулах газар талбайгүй, уул уурхайн компаниудын ашигласан талбайд зөвшөөрөлгүйгээр алт олборлож амьжиргаагаа залгуулж байгаа нь нийтлэг ажиглагдаж байна. Судалгаанд оролцсон бичил уурхайчид орон нутгийн удирдлагууд бичил уурхайчдыг дэмждэггүй, бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журмын хүрээнд зохион

байгуулалтад оруулах, ахуй амьдралынх нь талаар санал бодлыг нь сонсож байсан тохиолдол огт байхгүй гэж үзлээ

- Малчдын өвөлжөө хаваржааны газрын эзэмшил, нөхөн төлбөр, уул уурхайн компаниудын нийгмийн хариуцлага гэх мэт малчин хүний эрх ашиг, эрх, эрх чөлөөнд хамааралтай асуудлын талаар хангалттай мэдээлэлгүй байгаа нь малчдын газар эзэмших, ашиглах, өмчлөх, өвөлжөө бууцаа хамгаалах, оршин суух эрхэнд нь халдах боломжийг нийгмийн хариуцлагагүй, хууль дээдэлдэггүй уул уурхайн компаниудад олгож байна.
- Ашигт малтмалын тухай хуулийн 41 дүгээр зүйлд “Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хайгуулын болон ашиглалтын үйл ажиллагааны явцад худаг, өвөлжөө, хувийн болон нийтийн зориулалттай орон байр бусад барилга байгууламж болон түүх, соёлын дурсгалт зүйлсэд гэм хор учруулсан бол хохирлыг нь өмчлөгч, эзэмшигчид бүрэн хэмжээгээр нөхөн төлөх бөгөөд шаардлагатай тохиолдолд тэдгээрийг шилжүүлэн байрлуулахтай холбогдсон зардлыг хариуцна.” гэж заасан. Уянга сумын Өлт багийн малчид уул уурхайн үйл ажиллагааны нөлөөлөлд өртснөөс цөөн тооны малчид уул уурхайн компанитай харилцан тохиролцож өвөлжөө, хаваржааны газраа алдсаны нөхөн төлбөр авч байгаа нь судалгаагаар харагдаж байлаа.

Дөрөв. Бичил уурхай эрхлэгчдийн эрүүл, аюулгүй орчинд аж төрөх, эрүүл мэндээ хамгаалуулах эрхийн хэрэгжилт

- Бичил уурхай эрхэлж байгаа иргэдийн ажлын нөхцөл хүнд, тэднийг эрүүл мэндээрээ хохирох, амь насаа алдах эрсдэл байнга дагаж байдгийг ХАМО иргэд, орон нутгийн удирдлагуудтай хийсэн ярилцлагын дүн харуулж байна.
- 2000 онтой харьцуулахад холбогдох хууль тогтоомжид нааштай өөрчлөлт орж бичил уурхайн эрх зүйн орчин бүрдсэн ч орон нутгийн удирдлага хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд хойрго хандаж байгаа нь ХАМО иргэдийн хөдөлмөрлөх, эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангаж, хамгаалахад саад тотгор учруулж байна.
- Түүнчлэн орон нутгийн удирдлага, эмч, цагдаагийн ажилтан, албан хаагчдын зүгээс ХАМО иргэдэд жирийн иргэний адил хандаж үйлчлэх соёл төлөвшөөгүй байна. Тухайлбал эмч, эмнэлгийн ажилтнууд ХАМО нарыг үхэлд хүргэх өвчин эмгэг тусах, гэмтэл авахаас бусад тохиолдолд эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлдэггүй, ХАМО иргэдэд ялгавартай хандах тохиолдол гарч байна.
- Судалгааны дүнгээс харахад ХАМО иргэд нуруу бөөр, сав, хөлний судас бүдүүрэх, харшил, астам, амьсгалын замын өвчнөөр түгээмэл өвдөж байгаа бөгөөд ихэнх нь эрүүл мэндийн болон нийгмийн даатгалд хамрагдаагүйгээс эмнэлэгийн болон нийгмийн халамжийн тусламж, үйлчилгээ авах эрхээ эдэлж чадахгүйд хүрч байна.
- ХАМО иргэд эрүүл ахуйн шаардлага хангаагүй, орчны бохирдол ихтэй газар ажиллаж, амьдарч байна. Бичил уурхай эрхэлж байгаа иргэдийн оршин суугаа газрын орчин нөхцөл нь хог шороондоо дарагдсан, хогон дунд хүүхдүүд тоглож, өсч бойжиж байгаа дүр зураг харагдаж байсан бөгөөд үүнд бичил уурхайчид, орон нутгийн засаг захиргаа, төр засгийн аль аль нь анхаарал хандуулалгүй өдийг хүрчээ.
- Судалгаанд хамрагдсан бичил уурхайчид уул уурхайн үйл ажиллагааны улмаас эрүүл мэнд, амь насаараа хохирсон 40 тохиолдлын 24-т нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авсан бол, үлдсэн 16 тохиолдолд нь энэ төрлийн тусламж үйлчилгээнд хамрагдаж чадаагүй байна. Судалгааны дүнгээс харахад уул уурхайн үйл ажиллагааны улмаас бичил уурхай эрхлэгчид, нутгийн иргэдийн эрүүл аюулгүй орчинд аж төрөх, эмнэлгийн тусламж авах, эрүүл мэндээ хамгаалуулах эрхүүд зөрчигдөж, өвчлөл нэмэгдэж байна.

Тав. Бичил уурхай эрхлэгч иргэдийн эрх эрх чөлөөг хангаж хамгаалах үүрэгтэй институт, субъектүүдийн хүний эрхийг хангаж хамгаалах талаар авч хэрэгжүүлж буй үйл ажиллагаа

- Иргэдийн эрхийг ямарваа ялгаварлан гадуурхалгүйгээр хангаж хамгаалах үүрэг хүлээсэн субъектүүд болох сум орон нутгийн засаг захиргаа, холбогдох мэргэжилтнүүд иргэдээ бүртгэлтэй оршин суугч эсэхээр нь, хувиараа ашигт малтмал олборлож байгаа иргэдийг эрхэлж байгаа ажлаар нь ялгаварлан гадуурхаж хүнлэг бус харьцах, “нинжа” гэх мэтээр доромжилдог явдал нийтлэг үзэгдэл болсон байна.
- Дээр дурдсан иргэдийн эрхийг зөрчдөг, зодож дарамтлан эрх чөлөөнд нь хууль бусаар халддаг, хүнлэг бус ханддаг уул уурхайн компаниудын хамгаалалтын ажилтнуудад орон нутгийн засаг захиргаа, цагдаагийн байгууллага арга хэмжээ авдаггүйгээс ХАМО иргэдийн эрх, эрх чөлөөнд халдсан зөрчил байнга гардаг төдийгүй эрх нь зөрчигдөгдөж байгаад ХАМО иргэд өөрсдөө буруутай гэх хандлага уул уурхайн компанийн ажилтнууд болон орон нутгийн удирдлагуудад нийтлэг байгаа нь иргэдийнхээ эрх, эрх чөлөөг үнэгүйдүүлэхэд хүргэж байна.
- Судалгаанд хамрагдсан иргэд, малчдын өгсөн мэдээлэлд хийсэн шинжилгээгээр орон нутгийн удирдлага, уул уурхайн компаниудын эрх ашиг, сонирхол нэгддэг, уул уурхайн үйл ажиллагааны улмаас ХАМО иргэд, нутгийн иргэдэд үүсч буй хүний эрхийн зөрчлүүдийг үгүйсгэдэг, тэднийг буруутгадаг, хүч хэрэглэдэг явдал газар авчээ. Судалгаанд хамрагдсан ХАМО иргэд, нутгийн иргэдийн үзснээр орон нутгийн захиргаа нь мөнгөтэй уул уурхайн компаниудын эрх ашигт үйлчилдэг, цагдаагийн байгууллагатай хамтран ХАМО иргэдийг баривчлах, бичил уурхайн үйл ажиллагаанд ашигладаг багаж төхөөрөмжийг нь хураах, эвдлэх цаашлаад зодож цохих зэргээр бие махбодид нь дураараа халдах, айлган сүрдүүлэх, заналхийлэх зэрэг хүний эрхийн суурь зарчмууд, Монгол улсын Үндсэн хууль, Монгол Улсын нэгдэн орсон хүний эрхийн гэрээ конвенцүүдийн үзэл санаа, заалтуудыг зөрчсөн үйлдлийг байнга гаргаж байна. Орон нутгийн захиргааны байгууллага нь хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хүлээдэг, гэтэл судалгааны баримтуудаас харахад уул уурхайн үйл ажиллагааны уул уурхайн компаниудад эзэмшиж буй бэлчээрийн газраа алдсан, бэлчээрийн газраасаа шахагдаж малгүй, газаргүй, орлогогүй болсон малчид, амьд явах, эрүүл аюулгүй орчинд аж төрөх, эрүүл мэндээ хамгаалуулах эрх нь хамгийн их зөрчигдөж байгаа ХАМО иргэдийн хүний эрхийн асуудал сэтгэл түгшээсэн асуудал хэвээр байхад хүний эрхийн зөрчлийг бууруулахад чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлэхгүй өдийг хүрчээ.
- ХАМО иргэдэд мэдлэг мэдээлэл хүргэх, дэмжлэг туслалцаа үзүүлэх, чадавхижуулах, тэдний аюулгүй ажиллагааг хангах чиглэлээр ажилладаг Швейцарийн хөгжлийн агентлаг болон эрүүл мэндийн чиглэлээр хэрэгждэг ганц нэг төслийг эс тооцвол тэдэнд анхаарал тавьдаг, тэдний эрхийг нь хамгаалах өөр байгууллага өнөөдрийг хүртэл байхгүй байна. Бичил уурхайчдын үзэж байгаагаар ХАМО иргэд нь нийгмээс тусгаарлагдсан, ялгаварлан гадуурхагдсан, шоовдоглогдсон хэвээр байна. Гэтэл бичил уурхайн салбар дэлхий дахинд хөгжөөд 100 жил болсон, уул уурхайн салбараас дутахгүй нэр хүндтэй, улс орны эдийн засагт хувь нэмэр оруулдаг, нийгмийн хариуцлагатай, байгаль орчиндоо ээлтэй үйл ажиллагаа явуулдаг талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр олонтаа ярьдаг ч манай орны хувьд бичил уурхай эрхлэгчдийн амьдрал ахуйд төрийн болон орон нутгийн засаг захиргааны байгууллагууд, олон улсын байгууллага, ТББ-уудын аль нь ч анхаарал хандуулж тодорхой арга хэмжээ авахгүй байсаар байна.
- Монгол Улсын Үндсэн хуулийн 19-д “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг

зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” гэж төрийн хүлээх үүргийг тодорхойлсон ч орон нутгийн засаг захиргаа энэхүү үүргээ биелүүлэхгүй байгаа нь ХАМО иргэдийг анхаардаг, тусалж дэмждэг төр засаг байхгүй “хаягдсан, шоовдорлогдсон хүмүүс”, гэж үзэж байгаагаас харагдаж байна.

- Төр засгийн бодлогыг хэрэгжүүлэх үүрэгтэй орон нутгийн засаг захиргаа, удирдлагууд бичил уурхай эрхлэгчдийн газар эзэмших, ашиглах, өмчлөх эрхийг хэрэгжүүлэх хүрээнд хэрэгжүүлсэн, санаачилсан, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ огт байхгүй байна. Харин Заамар сумын хувьд 50 ХАМО иргэнийг нөхөрлөлийн зохион байгуулалтаар бичил уурхай эрхлэх боломжоор хангажээ.

Зургаа. Бичил уурхай эрхлэгчдийн оролцооны эрхийн хэрэгжилт

- Асуулга судалгаанд хамрагдсан ХАМО иргэдийн уул уурхайтай холбоотой асуудлаарх Үндсэн хуулиар олгогдсон оролцооны эрхийн хэрэгжилт хангалтгүй байгаа нь орон нутгийн удирдлагуудад иргэдийн зүгээс өгсөн өргөдөл гомдлын шийдвэрлэлт тааруу буюу маш муу гэж 71.3 хувь нь хариулснаас харагдаж байна.
- 80.8 хувь нь орон нутгийн удирдлага иргэдийн эрх ашгийг хөндсөн шийдвэр гаргахдаа иргэдийн оролцоог хангасан байдлыг тааруухан гэж үнэлсэн нь иргэдийн оролцооны эрхийн хэрэгжилт хангалтгүй байгааг илтгэж байна.
- Судалгаанд хамрагдсан ХАМО иргэдийн дийлэнх нь буюу 62.4 хувь нь сүүлийн нэг жилд хурал уулзалтад оролцож мэдээлэл авч байгаагүй гэж хариулснаас үзвэл мэдээлэл авах эрхийн хэрэгжилт хангалтгүй байна.
- Судалгааны дүнгээс харахад ашигт малтмал олборлох, ашиглах, нөхөн сэргээх үйл явцад орон нутгийн иргэдийн оролцоо хангалтгүй байна. Ашигт малтмалын тухай хуулинд ашигт малтмал ашиглах эрхийг хуулийн этгээдэд өгөхөд орон нутгийн орон нутгийн ИТХ-ын шийдвэрээр олгоно гэж заасан нь орон нутгийн иргэдийн саналыг харгалзах ёстойг харуулж байгаа ч зөвхөн сумын Засаг дарга, ИТХ-ыг гишүүдийн шийдвэрээр асуудлыг шийдвэрлэж байгаа нь хуулийг байнга зөрчиж байгааг харуулаад зогсохгүй иргэдийн Үндсэн хуулиар олгогдсон оролцоо эрхийг ноцтойгоор зөрчиж байна.
- Нутгийн иргэд, ХАМО иргэд орон нутагт нь ямар ямар уурхайн компаниуд, хэдэн жилээр үйл ажиллагаа явуулж байгаа, нөхөн сэргээлт хийдэг эсэх, уул уурхайн үйл ажиллагаанаас орон нутагт орж ирсэн хөрөнгө оруулалт, түүний зарцуулалтын талаар огт мэдээлэлгүй байна.

Долоо. Уул уурхайн үйл ажиллагааны байгалийн нөөц болон уламжлалт бэлчээрийн мал аж ахуй, малчдын амьжиргаанд үзүүлж буй нөлөө, нөхөн төлбөр, байгалийн нөхөн сэргээлт

- Судалгаанд хамрагдсан Уянга сумын Өлтийн хөндий, Заамар сумын Хайлааст багийн нутагт уул уурхайн үйл ажиллагааны нөлөөллөөс үүдэн уламжлалт бэлчээрийн мал аж ахуй эрхлэх аргагүй нөхцөл байдалд хүрч байгааг судалгаанд оролцогчид хэлж байлаа.
- Судалгаанд хамрагдсан малчид нийт бэлчээрийн талбайн 70 гаруй хувь нь уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орж талхлагдсан, гол усны гольдролыг өөрчлөн алт угааснаас ус бохирдож унданд хэрэглэх аргагүй болсон, уул уурхайн тээвэрлэлт гүйцэтгэдэг хүнд даацын машинууд зам, хөрс, бэлчээрийг талхалсан гэж үзэж байна.

- Ашигт малтмалын газраас орон нутагт хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгохдоо нутгийн иргэдийн оролцооны эрхийг үл ойшоож, шийдвэр гаргадаг, уугуул буюу хэдэн үеэрээ үе залгамжлан нутаглаж, уламжлалт бэлчээрийн МАА-гаа эрхлэн амьдарч ирсэн нутаг орны экосистем, байгаль орчныг уул уурхайн компаниуд сүйтгэж, сүйрүүлж байгаад маш их эмзэглэж байлаа.
- Уул уурхайн компаниуд нь төр засгийн эрх мэдэлтнүүд, орон нутгийн захиргаатай ашиг сонирхол нэгдэж хууль хэрэгжүүлдэггүй, дуртай газраа ухаж сэндийчдэг, малчдын үеэс үе уламжлан нутаглаж, нүүдлийн мал аж ахуйгаа эрхэлж ирсэн өвөлжөө, хаваржааны газрыг булааж, өвөлжөө бууцаа орхиж нүүхээс өөр аргагүй шахаанд оруулж байгааг малчид хэлж байна.
- Уул уурхайн компаниуд малчдын бэлчээр, газар нутгийг булаасан, уурхайн зориулалтаар авсан тохиолдолд цөөн тооны малчдад 2-3 жилийн хугацаагаар нөхөн төлбөр өгөх гэрээ байгуулсныг эс тооцвол нөхөн төлбөрийн төлбөрийн асуудлаар орон нутгийн захиргааны оролцоо байхгүй зөвхөн компани малчдын харилцан тохиролцоогоор асуудлыг шийдэж байна. Орон нутгийн удирдлагууд ч үүнд оролцох сонирхолгүй байгаа нь судалгааны явцад ажиглагдаж байлаа.
- Уул уурхайн компаниуд уул уурхайн үйл ажиллагааны улмаас сүйтгэсэн талхалсан газар нутаг, экосистемийг нөхөн сэргээсэн, унаган төрхөнд нь оруулсан үйл ажиллагаа хангалтгүй байна гэж малчид, иргэд үзлээ. Малчид уул уурхайн компаниуд хамгийн сайхан ус, бэлчээртэй газрыг нь ухаж усгүй, бэлчээргүй, тоос түйрэн болгоод орхиж байгаад хамгийн их санаа нь зовж байна.
- Сумын орон нутгийн захиргааны байгууллагад уул уурхайн нөлөөлөлд өртсөн малчдыг нүүлгэн шилжүүлэх, газар чөлөөлөлт, малчдын өвөлжөө хаваржааны эзэмшил түүний нөхөн төлбөрийн асуудлыг зохицуулах асуудлын хүрээнд авч хэрэгжүүлж байгаа бодлого, арга хэмжээ огт байхгүй байна.
- Уул уурхайн үйл ажиллагааны сөрөг нөлөөллийн улмаас өвөлжөө, хаваржаа, намаржааны газаргүй болсон, мал маллах аргагүйд хүрсэн улмаар газар эзэмших эрхээ эдэлж чадахгүйд хүрсэн олон жишээ баримтуудыг судалгаанд оролцогчид хэлж байгаа ч уул уурхайн нөлөөлөлд өртөж хохирсон малчдад газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтийн арга хэмжээг авсан уул уурхайн компани байсангүй.
- Уул уурхайн компаниуд стандартын дагуу нөхөн сэргээлтийн үйл ажиллагаа явуулж чадахгүй байгааг орон нутгийн малчид, бичил уурхайгаар ашигт малтмал эрхлэгчид үзлээ. Судалгаанд хамрагдсан Уянга, Заамар сумдад нуруулдах, тэгшлэх, ковш гүйлгэх зэргээр техникийн нөхөн сэргээлт хийгээд орхидог, биологийн нөхөн сэргээлт огт хийгээгүй байна.

ЗӨВЛӨМЖ

“Монгол Улс дахь бичил уурхай ба хүний эрх” судалгааны үр дүн, дүгнэлтэд тулгуурлан гаргасан зөвлөмж

Нэг. УИХ, Засгийн газар, төрийн захиргааны төв байгууллагуудад

1. Монгол Улсын Их Хурлаас 2010 онд Ашигт малтмалын тухай хууль, Газрын тухай хууль, Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ эрхлэгч иргэний орлогын албан татварын тухай хуульд тус тус нэмэлт өөрчлөлт оруулж, улмаар Засгийн газраас “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам”-ыг баталсантай холбогдуулан дээрх хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангахад зохион байгуулалтын болон зохицуулалтын арга хэмжээ авах үүрэгтэй төрийн захиргааны төв байгууллага, хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавьж байх үүрэгтэй Засгийн газрын хэрэгжүүлэгч, тохируулагч агентлагууд, түүнийг хэрэгжүүлэх ажлыг нутаг дэвсгэртээ зохион байгуулж, ажиллах үүрэгтэй аймаг, Нийслэлийн Засаг дарга нар түүний, албан хаагчид дээрх үүргээ биелүүлэхдээ эдгээр хууль тогтоомжийг орон нутагт сурталчлан таниулахад чиглэсэн дорвитой ажлыг зохион байгуулах шаардлагатай байна.
2. Уул уурхайн компаниудын зүгээс бүртгэгдээгүй нөхөрлөлийн зохион байгуулалтад орсон бичил уурхайчидтай гэрээ байгуулж, уурхайн талбайд ажиллуулах үйл ажиллагаа хангалтгүй байна. Иймд уул уурхайн компаниудад бичил уурхайн холбогдолтой хууль тогтоомжийг таниулах, сурталчлах, сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх, уул уурхайн компаниуд болон бичил уурхайчдын хооронд хамтын ажиллагаа бий болгоход чиглэсэн нөлөөллийн үйл ажиллагааг дээр дурдсан төрийн байгууллагуудын зүгээс явуулах шаардлагатай байна. Ингэхдээ бичил уурхайчидтай хамтарч ажиллах нь уул уурхайн компани, хувиараа болон бичил уурхайгаар ашигт малтмал олборлогч иргэдийн хооронд гардаг зөрчил, маргааныг шийдвэрлэх, осол гэмтэл гарахаас урьдчилан сэргийлэх, аливаа асуудлыг хамтарч шийдэх сайн талтайг ойлгуулах нь чухал.
3. Орон нутагт ажлын байр бий болгох, ядуурлыг бууруулах зорилгоор хувиараа болон бичил уурхайгаар ашигт малтмал олборлож байгаа иргэдтэй хамтран ажиллаж, нийгмийн хариуцлагаа ухамсарлаж буй уул уурхайн компаниудыг урамшуулах, хөхиүлэн дэмжих, бий болгосон ажлын байрны тооноос хамааруулан татварын хөнгөлөлт үзүүлэх зэрэг эдийн засгийн хөшүүргийг бий болгох эрх зүйн орчныг бүрдүүлж, бодлогоор дэмжих,
4. “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам”-д ХАМО иргэд бичил уурхайгаар ашигт малтмал олборлохын тулд тухайн орон нутагт оршин суугчаар бүртгүүлсэн байх шаардлагыг уян хатан болгох,
5. Ашигт малтмалын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.4-т зааснаар аймаг, Нийслэлийн Засаг дарга тухайн орон нутагт ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох тухай төрийн захиргааны байгууллагын мэдэгдлийг хүлээн аваад тухайн сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн саналыг авч 30 хоногийн дотор төрийн захиргааны байгууллагад хариу өгөх бөгөөд энэ хугацаанд хариу өгөөгүй бол тухайн саналыг зөвшөөрсөн гэж үзэхээр зохицуулсан. Гэсэн ч уг заалтын хэрэгжилт бодит байдал дээр хангалтгүй байгаа тул орон нутагт хуулиар олгогдож баталгаажсан эрхийг нь эдлүүлэх, уул уурхайн асуудлаар нутгийн иргэдийн Үндсэн хуулиар олгогдсон үгээ хэлэх, саналаа гаргах, шийдвэр гаргахад оролцох эрхийг нь хэрэгжүүлэх боломж нөхцлөөр хангахад төрөөс анхаарах,

6. Орон нутагт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх тусгай зөвшөөрөл авсан компаниуд нөхөн сэргээлт хийх нэрээр алт олборлож байгааг анхаарч хяналт, шалгалтыг тодорхой хугацаа, давтамжтайгаар явуулах, энэ талын мэдээллийг иргэдэд ил тод, нээлттэйгээр мэдээлдэг байх,
7. Эрх нь зөрчигдөж байгаа иргэдийн хууль ёсны эрх ашгийг хамгаалах үүрэг хүлээсэн орон нутгийн удирдлага, цагдаа, эмнэлгийн байгууллагын ажилтнуудын мэргэжлийн ёс зүй, ажил үүргээ гүйцэтгэж буй байдалд хяналт тавьдаг, энэхүү үүрэг хариуцлагаа биелүүлээгүй, мэргэжлийн ёс зүйгээ баримтлаагүй төрийн албан хаагчдад хариуцлага тооцох, төрийн албан хаагчдын зан үйл, хандлагыг өөрчлөх, харилцааны чадавхийг бэхжүүлэх,
8. Бичил уурхай эрхлэгчдэд уул уурхайн салбар дахь хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, хөдөлмөр хамгаалал, эрүүл мэндийн болон нийгмийн халамжийн асуудлаар мэргэжлийн байгууллагууд, олон улсын байгууллагуудтай хамтарсан сургалтуудыг явуулж хэвшүүлэх,
9. Уянга суманд бичил уурхай эрхэлж буй иргэдийн эрх, эрх чөлөөг хангах, тэднийг чадавхижуулахад чиглэсэн төсөл, хөтөлбөрүүд хангалтгүй байгааг анхаарч цаашид олон улсын байгууллагуудын дэмжлэгтэй төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх,
10. Швейцарийн хөгжлийн агентлагийн “Тогтвортой бичил уурхай” төслийн бичил уурхай эрхлэгчдэд зориулан хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөр, үйл ажиллагаа, туршлагыг үндэсний хэмжээнд түгээн дэлгэрүүлэх, хамтарч ажиллах тал дээр орон нутгийн удирдлагууд хамтарч ажиллах

Хоёр. Нутгийн захиргааны болон өөрөө удирдах байгууллагад

11. Судалгааны дүнгээс харахад ХАМО иргэдийн амьд явах, оршин суух газраа сонгох, амьдралын хүрэлцээтэй түвшинд аж төрөх, нэр төртэй амьдрах, эрүүл аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах, газар эзэмших, хөдөлмөрлөх, эмнэлгийн тусламж авах, үр хүүхэд нь сурч боловсрох, хөгжих эрхүүд нь хязгаарлагдаж, зөрчигдсөөр байна. ХАМО иргэдийн эрхийг хангаж хамгаалахад чухал үүрэгтэй субъектүүд болох нутгийн өөрөө удирдах байгууллага, эмнэлэг, халамжийн байгууллагууд хуулийн хүрээнд ялгаварлан гадуурхал, хүнд суртал гаргалгүй, төрийн албан хаагчийн болон мэргэжлийн ёс зүйг сахин төрийн үйлчилгээг хүргэж ажиллах,
12. Бичил уурхайн талаар төрөөс баримталж байгаа бодлого шийдвэр, хууль тогтоомж, орон нутгаас хууль тогтоомжийг хэрэгжүүлэх хүрээнд авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаарх мэдээллэл, ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшиж байгаа хуулийн этгээдийн нэр хаяг, тусгай зөвшөөрлөөр олгосон талбайн хэмжээ, хил зааг, тусгай зөвшөөрлийн шилжилт хөдөлгөөний талаарх мэдээллэл, нөхөн сэргээлт хийж байгаа компаниуд, бичил уурхайн нөхөрлөлүүд, бичил уурхайн зориулалтаар орон нутгийн тусгай хэрэгцээнд авсан газрын талаарх хуулиар хориглоогүй мэдээллийг боломжит бүх эх сурвалжаар иргэд, малчид, бичил уурхайчид болон сонирхсон хүмүүст ил тод, нээлттэйгээр тогтмол мэдээлдэг байх
13. “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам”-д заасанчлан бичил уурхайгаар ашигт малтмал олборлох иргэдийг нөхөрлөлийн хэлбэрээр зохион байгуулалтад орж, тухайн орон нутагт албан ёсны бүртгэлтэй болох үйл ажиллагааг дэмжих, мэргэжил арга зүйн зөвлөлгөө өгөх,
14. Уул уурхайн зориулалтаар ашиглагдсан буюу орхигдсон газарт ашигт малтмал олборлох үйл ажиллагаа явуулж байгаа ХАМО иргэдэд нөхөрлөл байгуулж хууль тогтоомжийн дагуу олборлолт явуулахад нь бүх талын дэмжлэг тусалцаа үзүүлэх нь зүйтэй. Судалгаанд оролцсон ХАМО иргэд өмнө нь уурхайн зориулалтаар ашиглагдсан, орхигдсон газарт олборлолт явуулах хүсэлтэйгээ илэрхийлж байсан,

- иймд тэдэнд хууль тогтоомжийн хүрээнд албан ёсны олборлолт явуулах эрхийг нь эдлүүлэх, олборлолтын газрын асуудлыг шийдвэрлэхэд анхаарч ажиллах, энэ талаар хуулиар хүлээсэн үүргээ биелүүлж ажиллах
15. Уул уурхайн компаниудаас орон нутгийн захиргаанд өгдөг хандив тусламжийг орон нутагт ажлын байр бий болгох, ялангуяа залуучуудыг ажлын байраар хангахад зарцуулахыг иргэд санал болгож байсан. Иймд уул уурхайн компаниудын өгсөн хандив тусламжийг суварга босгох, наадмын талбай барихаас илүүтэйгээр нийтийн эрх ашигт нийцсэн, нутгийн иргэдийн санал хүсэлтийг харгалзан үйл ажиллагаанд зориулахад анхаарч шийдвэрлэх,
 16. Уул уурхайн үйл ажиллагаа нь уугуул иргэд, малчдын уламжлалт бэлчээрийн мал аж ахуй, тэдний амьдралын хэв маягт сөргөөр нөлөөлж байгаа олон жишээ баримтуудыг судалгааны үр дүнгээр харуулсан. Уул уурхайн компаниуд хууль бусаар малчдын өвөлжөө хаваржааг уул уурхайн эдэлбэр газрын зориулалтаар ухдаг, сэндийлдэг хууль бус үйл ажиллагааг таслан зогсоход орон нутгийн засаг захиргааны байгууллагууд, мэргэжлийн хяналтын болон хууль хяналтын байгууллагууд анхаарал хандуулж, хууль бус үйлдлийг таслан зогсоох,
 17. Уул уурхайн компаниуд уул уурхайн үйл ажиллагааны улмаас нутгийн иргэдийн эзэмшлийн өвөлжөө, хаваржааны газрыг чөлөөлөх, нүүлгэн шилжүүлэх, нөхөн төлбөр төлөлтийн асуудлыг шийдвэрлэх явцад уугуул иргэдийн эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдөхгүй байхаар хууль тогтоомжийн хүрээнд шийдэж байгаа эсэхэд хяналт тавьж, эрх нь зөрчигдсэн тохиолдолд зөрчигдсэн эрхийг сэргээх арга хэмжээг авч хэрэгжүүлэх,
 18. Орон нутгийн удирдлагууд бичил уурхайн үйл ажиллагаа эрхэлж байгаа насанд хүрээгүй хүүхдүүдийг сурч боловсрох, хөгжих, эрүүл мэндээ хамгаалуулах эрхийг нь хангахад чиглэсэн арга хэмжээг эмнэлэг, сургууль, сургуулийн өмнөх боловсролын байгууллагатай хамтран хэрэгжүүлэх,
 19. ХАМО иргэдийн эрх хамгийн ихээр зөрчигддөг эрүүл мэнд, нийгмийн үйлчилгээний салбарын хүртээмжийг нэмэгдүүлэхэд орон нутгийн удирдлага анхаарах,

Гурав. Төсөл хэрэгжүүлэгч олон улсын болон төрийн бус байгууллагуудад,

20. Бичил уурхай бүхий сумдад үйл ажиллагаа явуулж байгаа уул уурхайн компаниудын удирдлага, харуул хамгаалалтын ажилтнуудад хүний эрхийн болон хууль эрх зүйн мэдлэг олгох сургалтуудыг зохион байгуулах,
21. Нутгийн иргэд, уул уурхайн компаниуд, бичил уурхайчид болон орон нутгийн удирдлага хоорондын зөрчлийг зөвшилцөх, ойлголцох замаар шийдвэрлэхэд нөлөөлөх, хамтын ажиллагаа бий болгоход зуучлагчийн үүрэг гүйцэтгэж талуудад харилцан ашигтай шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлэх,
22. Орон нутгийн засаг захиргааны байгууллага, тэдгээрийн удирдлагууд, холбогдох мэргэжилтнүүд, ХАМО иргэдэд хүний эрх, эрх чөлөө, хүний эрхийн зөрчлийг арилгах, хүний эрхийн зөрчил гаргасан тохиолдолд хэнд ямар байгууллагад хандах, хүний эрхийг хангаж, хамгаалах механизм, хүний эрхийг хамгаалахад орон нутгийн захиргааны байгууллагын эрх, үүргийн талаарх сургалт, нөлөөллийн үйл ажиллагааг үе шаттайгаар зохион байгуулах,
23. Ашигт малтмалын тухай хууль, Газрын тухай хууль, Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам, хүний эрхийн талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтийг орон нутагт зохион байгуулах талаар нутгийн захиргааны болон өөрөө удирдах байгууллагууд бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардлагатай чадавхийг бэхжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа явуулж эдгээр субъектүүд хуулийн хэрэгжилтийг хангахад голлох үүрэгтэй болохыг ойлгуулах,

24. Зохион байгуулалтгүй хувиараа ашигт малтмал олборлож байгаа иргэдийг зохион байгуулалтад оруулах, аюулгүй, байгаль орчинд хор хөнөөлгүй, хариуцлагатай олборлолтын үйл ажиллагаа явуулах, хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн наад захын шаардлага хангасан нөхцөлд ажиллах, эрүүл мэндээ сахин хамгаалах талаар соён гэгээрүүлэх, чадавхижуулахад чиглэсэн арга хэмжээ авч хэрэгжүүлэх

Дөрөв. Хувиараа ашигт малтмал олборлогч иргэд, бичил уурхайн нөхөрлөлүүд, нутгийн иргэдэд

25. Хувиараа ашигт малтмал олборлогч иргэд бичил уурхайн холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулалтад орох, олборлолтын газрын асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар багийн Иргэдийн нийтийн хурлаар хэлэлцэх, хурлаас гарсан шийдвэр, газрын талаарх хүсэлтээ сумын ИТХ, ЗД-д албан ёсоор тавих, хуулийн хугацаанд хариу өгөөгүй тохиолдолд дээд шатны байгууллага, албан тушаалтанд асуудлыг тавих,
26. Хувиараа ашигт малтмал олборлогч иргэд, бичил уурхайн нөхөрлөлийн гишүүд олборлолтын үйл ажиллагаатай холбоотойгоор уул уурхайн компанийн харуул хамгаалалтын ажилтнууд болон цагдаа нарын халдлагад өртөх, зодуулж цохиулах, эрүүл мэнд, эд хөрөнгөөр хохирох тохиолдолд хууль хяналтын байгууллагад хандаж өргөдөл гомдлоо гаргах, шаардлагатай бол дээд шатны холбогдох байгууллага, хүний эрхийн байгууллага, иргэний нийгмийн байгууллагуудад хандах нь зүйтэй,
27. Ашигт малтмалын тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайтай давхцсан болон уул уурхайн үйл ажиллагааны улмаас өвөлжөө, хаваржааны газраа эзэмших эрх нь зөрчигдөж, мал аж ахуйгаа эрхлэн хөтлөх боломжгүй болсон иргэд өөрсдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл хууль тогтоомжийн дагуу зөрчигдсэн эрхээ сэргээлгэхээр шийдвэр гаргасан байгууллага эсхүл холбогдох эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хандах нь зүйтэй.

Тав. Уул уурхайн компаниудад

28. Уул уурхайн компаниуд орон нутагт ажлын байр бий болгох, ядуурлыг бууруулах замаар орон нутгийн тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулах үүргээ ухамсарлаж орон нутгийн удирдлага, иргэд, хувиараа ашигт малтмал олборлогч иргэд, бичил уурхайчидтай хамтран ажиллах гэрээ байгуулж иргэдийг ажлын байраар хангах, уурхайн олборлолт явуулсан талбайн ашигт малтмалын ашиглалтын болон технологийн хаягдал бүхий талбайд олборлолт явуулах боломж олгох, мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэхэд дэмжлэг үзүүлэх зэргээр нутгийн иргэдийн эрхийг хүндэтгэж нийгмийн хариуцлагатай үйл ажиллагаа явуулах нь зүйтэй.
29. Уул уурхайн компаниуд нь уул уурхайн үйл ажиллагааны улмаас нутаг бэлчээрээ алдсан, бэлчээр шахагдсан малчдын асуудлыг олон улсын стандартын дагуу газар чөлөөлөх, нүүлгэн шилжүүлэх, нөхөн төлбөр олгох хэлбэрээр шийдвэрлэх,
30. Уул уурхайн компаниуд уул уурхайн эдэлбэр газрын зориулалтаар ашигласан талбайг Байгаль орчныг хамгаалах тухай багц хуулийн дагуу нөхөн сэргээх арга хэмжээг авах.